

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны бүтээл нь 6 бүлэг бүхий үр дүнгийн тайлан, дүгнэлт, 18 хүснэгт, 19 дүрслэл, 5 хавсралтаас бүрдэж байна.

Судалгаанд баримтын болон чанарын судалгааны аргыг ашиглан, сумын эрүүл мэндийн төвийн ангилал (I.II.III зэрэглэл) тус бүрээр амбулатор, хэвтүүлэн эмчлэх, өрхийн эрүүл мэндийн төвийн амбулаторын, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өртгийг тооцоолон гаргалаа.

Өртгийн төвөөр амбулаторын тусламж, үйлчилгээнд 54 өвчний оношоор, хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд 47 өвчний оношоор нийт 101 өвчнийг өртгийн төвөөр сонгосон болно.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд сум, өрхийн эрүүл мэндийн өртгийн төвийг ижил өртгийн төвөөр буюу эх, хүүхдийн эрүүл мэнд, насны онцлогоос хамаарсан НЭМ-ийн тусламж, үйлчилгээ, халдварт ба халдварт бус гэсэн 4 багцын хүрээнд 16 чиглэлээр өртгийн төвийг тооцоолсон.

Энэхүү судалгаа нь “Үйлдэлд суурилсан өртөг тооцох арга”-ыг ашиглан, өртгийн төвөөр өвчний онош бүрээр, 1 үйлчлүүлэгчдэд ногдох зардлыг цалин, эм, эмнэлгийн хэрэгсэл, тогтмол зардал бүрээр задлан анхан шатны эмнэлгийн тусламж үйлчилгээг багцын өртгийг тооцооноороо ач холбогдолтой юм.

Судалгаанд 5 аймгийн 12 сумын эрүүл мэндийн төв, 2 өрхийн эрүүл мэндийн төв, УБ хотын 1 өрхийн эрүүл мэндийн төв, нийт 15 анхдагч шатлалын эрүүл мэндийн байгууллага хамрагдлаа. Судалгааны дүн шинжилгээнээс харахад сум, өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өртөгт хүний нөөцийн хангамж, тоо, тусламж, үйлчилгээ үзүүлэх хугацаа, алслагдмал байдал нөлөөлж байна.

Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн амбулатор, хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний нийт дундаж өртөг:

- I зэрэглэлд дундаж өртөг 10,718.0 төгрөг, цалингийн дундаж 4,869.0 төгрөг, эм, эмнэлгийн хэрэгслийн дундаж 2,865.0 төгрөг байна. Хэвтүүлэн эмчлэхэд I зэрэглэлийн нийт дундаж өртөг 119,588 төгрөг, цалин 38,049 төгрөг, эм, эмнэлгийн хэрэгслийн зардал 19,729 төгрөг
- II зэрэглэлд дундаж өртөг 12,511.0 төгрөг, цалин 3,886.0 төг, эм, эмнэлгийн хэрэгсэл 1,540.0 төгрөг байна. Хэвтүүлэн эмчлэхэд II зэрэглэлд дундаж өртөг 122,211.0 төгрөг, цалин 26,417.0 төгрөг, эм, эмнэлгийн хэрэгсэл 23,479.0 төгрөг байна.
- III зэрэглэлд нийт дундаж өртөг 13,177 төгрөг, цалин 3,950.0 төгрөг, төгрөгний зардалтай байна. Хэвтүүлэн эмчлэхэд III зэрэглэлд 130,003.0 төгрөг, цалин 36,365.0 төг, эм, эмнэлгийн хэрэгсэл 17,116.0 төгрөгний зардалтай байна.
- Өрхийн эрүүл мэндийн төвийн амбулаторын тусламж үйлчилгээний дундаж өртөг 9,121.0 төгрөг, үүнээс цалингийн зардал 5,579.0 төгрөг, эмнэлгийн хэрэгслийн зардал 4,219.0 төгрөг байна. Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эх, хүүхдийн нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцын нярайн гэрийн идэвхитэй эргэлт, вакцинжуулалт, сүрьеэ өвчний үед голомтод ариутгал хийх, хяналт тавих үйл ажиллагаа өндөр өртөгтэй байна.
- СЭМТ-ийн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний дундаж өртөг

Доороос дээш өртөг тооцох аргаар өртөг тооцоход 2013 оны СЭМТ-ийн нийт төсвийг 30-35 хувиар, ӨЭМТ-ийн төсвийг 60-85 хувиар нэмэгдүүлэх шаардлагатай байна.

## НЭГ. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, СУДЛАГДСАН БАЙДАЛ

Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амд тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлж, өвчлөл, эндэгдлийг тууштай бууруулахад чиглэдэг.

Энэхүү Мянганы хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэхэд өрх, сумын эрүүл мэндийн төв голлох үүрэгтэй ажилладаг.

Эрүүл мэндийн тухай хуулиар<sup>1</sup>:

Сум, тосгоны эрүүл мэндийн төв нь харьяа нутаг дэвсгэрийн хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны аргаар үзүүлдэг. Сум дундын эмнэлэг нь хүн амын нягтралаас хамааран харьяаллын болон зэргэлдээ сумын хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлдэг.

Өрхийн эрүүл мэндийн төв нь хот, суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага юм.


Өрх, сумын эрүүл мэндийн төв нь үйлчлэх хүрээний хүн амд нийгмийн эрүүл мэндийн болон эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийг дэмжих, лавлагаа тусламжинд илгээх, төрөлжсөн мэргэжлийн эмчийн зөвлөмжийн дагуу эмчилгээг эмнэлэг, гэрийн нөхцөлд үргэлжлүүлэх, хяналт тавих үндсэн чиг үүрэгтэй ажилладаг.

Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, үр ашгийг дээшлүүлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тулгуурлан эрсдэлт хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэхэд өртөг зардлын тооцоолол чухал юм.

Сумын эрүүл мэндийн төвийн өртгийн судалгааны шууд хөдөлмөрийн зардлыг тооцоход анхан шатанд ажиллаж байгаа эрүүл мэндийн ажиллах хүчний хангамж, нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээний үзүүлэлтүүд чухал юм.

2012 оны байдлаар Монгол улсын хэмжээнд сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг 329, өрхийн эрүүл мэндийн төв 221, нийт 550 анхан шатны эрүүл мэндийн байгууллагад 10769 эрүүл мэндийн ажиллах хүчин ажиллаж байна.

### ДҮРСЛЭЛ 1. АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ӨСӨЛТ




Сум, өрх, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн ажиллах хүчний 4 жилийн динамикт харьцангуй өөрчлөлт бага байснаа, 2012 онд 1.4%-иар, тоогоор авч үзвэл 151 хүнээр нэмэгдсэн байна. Өөрөөр хэлбэл анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэгч эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эрүүл мэндийн ажиллах хүчний тоо хэлбэлзэл багатай байна.

Их эмчийг мэргэжлээр авч үзвэл анхан шатны эрүүл мэндийн мэндийн байгууллагад 58.4% нь өрх, сумын, 18.3%-иар ерөнхий мэргэжлийн, 6.6%-иар хүүхдийн, 5.9%-иар дотрын, 3.7%-иар эх барих эмэгтэйчүүд тус тус ажиллаж байна.

<sup>1</sup> Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйл

## ДҮРСЛЭЛ 2. АНХАН ШАТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ИХ ЭМЧИЙН ТОО, ӨСӨЛТИЙН ДИНАМИК



2013 оны байдлаар өрхийн эрүүл мэндийн төвд 875 их эмч, сувилагч 812 ажиллан, жилд дунджаар 5.8 сая үзлэг хийгдэж, нэг иргэн 3.0 удаа өрхийн эмнэлгээр үйлчлүүлж байна. Амбулаторын үзлэгийн 42.2% нь урьдчилан сэргийлэх үзлэг эзэлж байна. <sup>2</sup>

Сумын эрүүл мэндийн төв нь 2013 онд батлагдсан “Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа”-ны стандартаар аймгийн төвөөс алслагдсан байдал, хүн амын тоо, аймгийн төв хүртэлх зорчих хугацаанаас хамааран 3 зэрэглэлд ангилагддаг.

Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгүүдийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын зарим үзүүлэлтийг авч үзвэл 3632 эмнэлгийн ор ажиллаж, 819 их эмч, 1639 сувилагч ажиллаж байна. Амбулаториор 2.348.234 хүн үзэж, 122.826 хүн хэвтэн эмчлүүлсэн байна. Жирэмсэний эрт үеийн хяналт 90.5%, урьдчилан сэргийлэх үзлэгийн амбулаторын үзлэгт эзлэх хувь 37.6%тай, эхийн эндэгдэл 100000 амьд төрөлтөд 67.0, нялхсын эндэгдэл 1000 амьд төрөлтөд 33.7 байна.<sup>3</sup> Анхан шатны тусламж, үйлчилгээний санхүүжилтийг эрсдэлт суурилсан нэг иргэнээр тооцсон аргачлалаар тооцон, улсын төсвөөс санхүүжүүлдэг.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өртгийн дараах судалгаанууд хийгдсэн байна. 1993 онд Анагаах ухааны хүрээлэнгийн судлаач И.Ядамсүрэн, Н.Оюунчимэг нарын судлаачид “Сумын эмнэлгийн амбулаторын нэгж үйлчилгээний өртөг” судалгааг хийсэн байна. Энэхүү судалгаагаар амбулаторын кабинетын нэгж үзлэгийн өртгийг тодорхойлох үндэслэлийг боловсруулсан нь эрүүл мэндийн эдийн засгийн үр ашгийг тооцох, эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд шилжихэд нэн тэргүүнд шаардагдах онол практикийн ач холбогдолтой<sup>4</sup> гэж дүгнэсэн байна.

2010-2011 онд ЭМЯ-аас аймаг, дүүргийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний өртгийн судалгааг хийсэн байна. Энэхүү судалгаагаар нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийг дэмжих үйлчилгээнд 1 иргэнд ногдох зардал 3477,6 төгрөг, амбулаторын үйлчилгээний нэг иргэнд ногдох өртөг нь 4911,9 төгрөг, хэвтүүлэн эмчлэх үйлчилгээний 1 хүнд дунджаар 203254,4 төгрөгний зардал гаргаж байна<sup>5</sup> гэсэн байна.

ЭМШУИС (хуучнаар) нь 2013 онд төв эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн үзүүлж буй тусламж, үйлчилгээний бодит өртгийг тооцох судалгаа хийсэн байна.

Энэхүү судалгаагаар хоёр болон гуравдугаар шатлалын эмнэлгүүдийн төсөвт ЭМДС-ийн гүйцэтгэх үүрэг нэмэгдэж, төсвийн хувь хэмжээ буурч байна. Энэ өсөлт нь ЭМЯ-наас баталсан тарифын өсөлттэй холбоотой. Сүүлийн 3-4 жилд ЭМДС-аас эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн тариф хурдацтай өссөн байна гэж <sup>6</sup> дүгнэсэн байна.

Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний өртгийн төвийг өвчний оношоор сонгон, амбулатор, хэвтэн эмчлүүлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээгээр багцаар нь тооцсон судалгаа байхгүй байна.

<sup>2</sup> Эрүүл мэндийн үзүүлэлт 2013 он, хуудас 45

<sup>3</sup> Эрүүл мэндийн үзүүлэлт 2013 он, хуудас 46

<sup>4</sup> И.Ядамсүрэн, Н.Оюунчимэг “Сум эмнэлгийн амбулаторын нэгж үйлчилгээний өртөг”, 1993 он

<sup>5</sup> Аймаг, дүүргийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний өртгийн судалгаа, 2009 он, хуудас 50

<sup>6</sup> Эмнэлгийн тусламж, үйлчилгээний бодит өртөг, ЭМШУИС, 2013 он, хуудас 78

Сум, өрхийн эрүүл мэндийн төвд нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр 40 орчим хөтөлбөр, стратеги, 310 гаруй төрлийн өвчний оношилгоо, эмчилгээг хийхээр баталсан.

Тухайлбал: Анхан шатны тусламж, үйлчилгээ нь Эрүүл Мэндийн Сайдын 2013 оны 7 сарын 08, 09-ний өдрийн 246, 248 тоот тушаалаар батлагдсан “Сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж үйлчилгээний багц”, “Өрхийн эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж үйлчилгээний багц”-д суурилдаг.

Энэхүү тусламж үйлчилгээний багцад 7 бүлэг, тус бүрдээ 310 орчим эмнэлзүйн удирдамж, оношилгоо хийх арга зүй, 4 бүлэг НЭМ-ийн тусламж, үйлчилгээний багц багтсан.

Шинэчлэгдэн батлагдсан тусламж үйлчилгээний багцын эмчилгээ, оношилгоонд шаардлагатай оношлуур, урвалж, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг нэмэгдүүлэхэд шийдвэр гаргагчдыг үндэслэл нотолгоотой мэдээллээр хангахад өртгийн судалгааны мэдээлэл чухал юм.

Иймд анхан шатны эрүүл мэндийн байгууллагын үзүүлж буй эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өртөг зардлыг тооцох, төсвийн төлөвлөлтөд ашиглах, шийдвэр гаргахад үндэслэл нотолгоотой мэдээллээр хангах нь энэхүү судалгааны ажлын үндэслэл болж байна.

### **Судалгааны зорилго:**

Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн амбулатор, хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өртөг тооцож, дүгнэлт гаргах

### **Зорилт:**

1. Сумын эрүүл мэндийн төвийн ангилал (I,II, III зэрэглэл) тус бүрээр амбулатор, хэвтүүлэн эмчлэх, оношлох өвчний өртөг тооцох
2. Өрхийн эрүүл мэндийн төвд эмчлэх, оношлох өвчний өртөг тооцох
3. Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өртөг тооцох
4. Анхан шатны тусламж, үйлчилгээний өртгийн нэгдсэн дүгнэлт гаргах

### **Судалгааны ажлын шинэлэг тал, ач холбогдол:**

- Энэхүү судалгаа нь сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж үйлчилгээний багц болон өрхийн эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж үйлчилгээний багц, сум, тосгон, өрхөд үзүүлэх тусламж үйлчилгээний эмнэлзүйн удирдамжинд тулгуурлан “Үйлдэлд суурилсан өртөг тооцох арга”-ыг ашиглаж байгаагаараа шинэлэг юм.
- Судалгаагаар анх удаа эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний өртгийг амбулатор, хэвтэн эмчлүүлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээгээр тооцон гаргаснаараа ач холбогдолтой.

### **Судалгаанаас гарах үр дүн:**

- Сум, өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өртөг багцаараа тодорхойлогдож, судалгааны ажлын тайлан гарсан байна.

### **Хэтийн үр дүн:**

- Судалгааны үр дүнг сум, өрхийн эрүүл мэндийн санхүүжилтийн шинэ хувилбарыг боловсруулах, нэмэгдүүлэх, тарифыг шинэчлэхэд ашиглана.

### **Судалгааны үе шат:**

Судалгааг дараах 3 үе шатаар хийлээ:

1. Асуумж судалгаа авах, дүн шинжилгээ хийх
2. Сум, өрхийн ЭМТ-ийн ажилтан бүрийн нэг минутанд авах дундаж цалингийн зардал, амбулатор, хэвтүүлэн эмчлэх тасгийн талбайгаар тооцсон тогтмол зардлыг тооцох
3. Нэг өвчтөнд зарцуулсан амбулатор, хэвтүүлэн эмчлэх, НЭМ-ийн дундаж хугацаа, хэрэглэсэн эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодисын зардлыг тооцох

**Санхүүжилт:** АХБ-ны Эрүүл мэндийн салбар хөгжил хөтөлбөр-3 төсөл

## ХОЁР. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

**Судалгааны аргачлал:** Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, үр ашгийг дээшлүүлэхэд өртгийн судалгааг амбулатор, хэвтүүлэн эмчлэх болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээр нь ангилан хоёр үе шаттай зохион байгууллаа.

Сум, өрхийн эрүүл мэндийн төвд оношлох, эмчлэх өвчин болон урьдчилан сэргийлэлт, нийгмийн эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа, зөвлөгөө, хяналтын өртгийг чанарын судалгааны аргад тулгуурлан баримтын шинжилгээ, ярилцлагын аргыг ашигласан. Өртөг тооцох олон арга байдаг. Олон аргуудаас боломжит байдлыг судалсны үндсэн дээр “Үйлдэлд суурилсан өртөг тооцох арга”-ыг ашиглан өртгийг тооцов.

**Судалгааны хамрах хүрээ ба түүвэр:** Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тусламж үйлчилгээний өртөг тооцоход 5 аймгийн 12 сумын эрүүл мэндийн төв, 2 өрхийн эрүүл мэндийн төв, УБ хотын 1 өрхийн эрүүл мэндийн төв, нийт 15 анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэгч эрүүл мэндийн байгууллагыг хамруулсан.

Судалгаанд хамрагдах аймаг, сумдыг тогтоохдоо энгийн санамсаргүй түүвэрлэлтийн аргыг ашиглан, дараах аймаг, сумдыг хамруулав.

Үүнд:

1. Дундговь аймгийн Адаацаг, Дэлгэрцогт, Говь-Угтаал сумын СЭМТ, ӨЭМТ-1
2. Төв аймгийн Баян, Баянжаргалан, Сэргэлэн сумын СЭМТ, ӨЭМТ-1
3. Ховд аймгийн Буянт, Дуут, Мөнххайрхан сумын СЭМТ
4. Хэнтий аймгийн Жаргалтхаан, Мөрөн, Цэнхэрмандал сумын СЭМТ
5. Улаанбаатар хотын БЗД-ийн “Эрүүл өрх” ӨЭМТ зэрэг байгууллагуудаас мэдээлэл цуглуулсан.

### **Мэдээлэл цуглуулалт, боловсруулалт:**

Баримтын судалгаагаар дараах холбогдох үзүүлэлтүүдийг цуглуулсан:

- Аймгийн Эрүүл мэндийн газрын 2012 оны статистик тайлан, нэгтгэл, эрүүл мэндийн байгууллагын анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэгч эрүүл мэндийн байгууллагын статистик, мэдээллийн бүртгэл
- Сумын эрүүл мэндийн төвийн барилгын план зураг, ажилчдын ажлын байрны тодорхойлолт, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр гүйцэтгэсэн ажлын тайлан
- Санхүүгийн тайлан, мэдээ
- Эмийн сан, эмийн эргэлтийн сангийн тайлан

Чанарын судалгаагаар амбулатор болон хэвтэн эмчлүүлэгчдэд тусламж үйлчилгээ үзүүлэхдээ ямар хугацаа зарцуулж буйг тодруулан ярилцаж, хугацааг тооцоход ашигласан. Өртгийн тооцооллыг хийхдээ 2012 оны тайлант оны санхүү, статистик бусад мэдээллийг суурь болгон авч ашиглав.

Үйлчлүүлэгчдэд үзүүлэх тусламж үйлчилгээний хугацаа, эмчилгээ, түүнд шаардагдах эм тариа, лабораторын урвалж бодисын талаарх мэдээллийн өгөгдлийг программд оруулж, боловсруулалтыг хийсэн.

### **Судалгаанд учирсан хүндрэл:**

Амбулатор, хэвтүүлэн эмчлэх болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой баримтын болон асуумж судалгааны мэдээлэл цуглуулах үйл явцад ямар нэг бэрхшээл гараагүй ба мэдээлэлд ямар нэг засварлалт хийгээгүй.

Харин өртөг тооцох өвчний явц буюу (анх, давтан, архаг) тохиолдлуудаар авч үзэх шаардлага гарсан бөгөөд эмнэлзүйн удирдамжинд зааснаар тохируулга хийн тооцсон нь цаг хугацаа алдахад хүргэж байлаа.

**Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний өртөг тооцоход баримталсан зарчим:** Өрхийн эрүүл мэндийн төвийн өртгийг тооцоход зардлуудыг дараах бүлэг болгон бүртгэж хувиарлалаа.

- Цалингийн зардал
- Эм, эмнэлгийн хэрэгслийн зардал

- Лаборатор, урвалж бодисын зардал
- Тогтмол зардал

Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний өртөг = Цалингийн зардал + Эм, эмнэлгийн хэрэгслийн зардал + лаборатор, урвалж бодисын зардал + тогтмол зардал гэж тооцсон болно.

**Цалингийн зардал:** Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн ажилтан бүрийн нэг үйлчлүүлэгчид зарцуулах дундаж цалин болон нэг минутад оногдох цалинг тооцоолсон.

Ингэхдээ сум, өрхийн эрүүл мэндийн төвд үйлчлүүлэгч орж ирээд, үйлчилгээ авч эхлээд, гарах хүртэлх зарцуулсан хугацааг тусламж үйлчилгээ үзүүлсэн ажилтан бүрээр тооцоолон, 1 минутад ногдох цалин тус бүрээр нь үржүүлэн, дундаж цалингийн зардлыг тооцсон.

**Эм, эмнэлгийн хэрэгслийн зардал:** Эм, эмнэлгийн хэрэгслийн зардлын орцыг тооцохдоо сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж үйлчилгээний багц, өрхийн эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж үйлчилгээний багцын дагуу эмнэлзүйн удирдамжийг ашигласан. Гэхдээ зарим нэг хүндрэл гарсан.

Эмнэлзүйн удирдамж ашиглах боломжгүй мэдээллийг эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй уулзан, чанарын судалгааны ярилцлагаар тодруулга авсан болно.

Тухайлбал: Эмнэлзүйн удирдамжийн дагуу, сонгосон өвчний чиглэлээр тусламж үйлчилгээ үзүүлэхэд ямар эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж шаардагдахыг тооцоолон асуулгаа гаргасан. Жишээ нь: тариа хэрэглэсэн гэвэл ямар тариаг хэдэн граммаар хийхэд ямар граммын тариур, хэдэн ширхэг ордог гэх мэтчилэн тооцоолсон.

Ингэснээр нэг үйлчлүүлэгчид зарцуулах эм, эмнэлгийн хэрэгслийн зардлыг тооцоолох боломж бүрдсэн.

Эм, эмнэлгийн хэрэгслийн үнийг тооцоолохдоо 2013 онд ЭМХТ-ийн Тогтолцооны судалгааны албаны хийсэн (хуучин нэрээр)“Тендерийн эмийн үнийн судалгаа”-ны үр дүнгээс эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодисын үнийг авч ашиглав.

Эмчилгээнд хэрэглэгдэж байгаа эмнэлгийн багаж тоног төхөөрөмжийн жилийн элэгдлийн дүнг тооцохдоо анх шинээр худалдан авах, хандивлахад хөрөнгийн бүртгэлд ямар үнээр, хэдэн жил ашиглахаар тооцон жилд элэгдүүлэх хэмжээг тооцсон.

Эмчилгээнд хэрэглэгдэж байгаа эмнэлгийн багаж тоног төхөөрөмжийн зардлыг тооцоолохдоо эмчилгээ, оношилгоонд багаж, тоног төхөөрөмж ашигласан бол жилийн элэгдлээс нэг минутад элэгдэхийг тооцож, хэдэн минут ашигласнаар үржүүлэн тооцсон.

#### **Лабораторийн урвалж, бодисын зардал:**

Лабораторид шинжилгээ хийсэн бол бодис, урвалжын зардлыг тооцон, эм, эмнэлгийн хэрэгслийн зардал дээр нэмсэн. Урвалж бодисын үнийг тооцохдоо “Тендерийн эмийн үнийн судалгаа”-ны үр дүнгээс авч ашиглав.

#### **Тогтмол зардал:**

Тогтмол зардалд эдийн засгийн ангиллын дагуу:

- Үндсэн цалин.,
- Нэмэгдэл урамшуулал.,
- Ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэл.,
- Эмийн зардал.,
- Хоолны зардал.,
- Хөтөлбөр арга хэмжээнээс бусад зардлыг оруулж тооцсон.

Зардлуудыг нэг цаг, нэг минутад гарах зардлаар тооцож тухайн үйлчлүүлэгч ямар хугацаагаар буюу хэдэн минутад сум, өрхийн эрүүл мэндийн төвд үйлчилгээ авснаар үржүүлж тогтмол зардлыг тооцсон. СЭМТ-ийн I,II,III зэрэглэлээс хамааруулахгүйгээр дундаж ор хоногийг 8 хоногоор авч нэг хоногт зарцуулах тогтмол зардлаар үржүүлж хэвтүүлэн эмчлэх хэсгийн тогтмол зардлыг тооцов. Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг амбулатор, хэвтүүлэн эмчлэх тусламжтай адил зарчмаар тооцсон болно.



## ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

### БҮЛЭГ 3.1. СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

#### 3.1.1. Сумын эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээний хүртээмжийн үзүүлэлт

Сумын эрүүл мэндийн төвийн өртгийн судалгааны шууд хөдөлмөрийн зардлыг тооцоход хүний нөөцийн үзүүлэлт чухал юм. 2013 оны байдлаар сумын эрүүл мэндийн төвд их эмч 611, сувилагч 1383, сум дундын эмнэлэгт их эмч 208, сувилагч 256, нийт 8184 ажилтан ажиллаж байна.

Сумын эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандартаар, аймгийн төвөөс алслагдсан байдал, хүн амын тоо, аймгийн төв хүртэлх зорчих хугацаанаас хамааран 3 зэрэглэлд ангилагддаг.

Үүнд:

- **I зэрэглэл** - Аймгийн төвөөс 50 км-ийн дотор болон 1 цаг хүртэлх хугацаанд зорчих сумын эрүүл мэндийн төв
- **II зэрэглэл** - Аймгийн төвөөс 50-99 км-ийн дотор болон 1-2 цаг хүртэлх хугацаанд зорчих сумын эрүүл мэндийн төв
- **III зэрэглэл** - Аймгийн төвөөс 100 км-ээс дээш болон 2 цагаас дээш хугацаанд зорчих сумын эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлэг

Нэгдүгээр зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төв нь аймгийн төвөөс 50 км-ээс дотогш боловч, үйлчлэх хүрээний хүн амын тоо 4500-аас дээш, хүн амын 70-аас дээш хувь нь сумын төвөөс алслагдсан, хүрч үйлчлэх хугацаа 1-2 цаг ба түүнээс дээш бол хоёрдугаар зэрэглэлд хамааруулна.

Хоёрдугаар зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төв нь 100 км-ээс дотогш боловч үйлчлэх хүрээний хүн амын тоо 8000-аас дээш, хүн амын 70-аас дээш хувь нь сумын төвөөс алслагдсан, хүрч үйлчлэх хугацаа 2 цаг ба түүнээс дээш бол гуравдугаар зэрэглэлд хамааруулдаг.

Сумын эрүүл мэндийн төв нь Нийгмийн эрүүл мэнд, хэвтүүлэн эмчлэх, оношилгоо, дэмжих үйлчилгээ гэсэн бүтэцтэй.

#### ХҮСНЭГТ 1. СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЗЭРЭГЛЭЛ, ИХ ЭМЧИЙН ТОО<sup>7</sup>

Зэрэглэл	Эмнэлгийн тоо	Эмчийн тоо (дундаж)	Стандартын түвшинд		Стандартаас доогуур	
			тоо	хувь	тоо	хувь
I зэрэглэл	17	2.8	15	88.2	2	11.8
II зэрэглэл	79	1.9	52	65.8	27	34.2
III зэрэглэл	175	2.8	133	76.0	42	24.0
Сум дундын эмнэлэг	39	5.7	5	12.8	34	87.2

I зэрэглэлийн сумын 11.8 хувь нь, II зэрэглэлийн сумын 34.2 хувь нь, III зэрэглэлийн сумын 24.0 хувь нь их эмч дутуу байна.

Өөрөөр хэлбэл 71 сумын эрүүл мэндийн төв, 34 сум дундын эмнэлэгт их эмч стандартад заасан тоогоор эмч ажиллахгүй байгаа нь их эмч хавсран ажиллах гол шалтгаан болж байна. Хөдөлмөрийн хуулиар ажил хавсран гүйцэтгэсэн тохиолдолд цалингийн 40 хувиар нэмэгдэл олгодог.

Энэ нь тухайн үйлчлүүлэгчид зарцуулсан хугацаа, нэг минутад ногдох дундаж цалин өндөр гарахад нөлөөлж байна. Өөрөөр хэлбэл өртгийн тооцоонд давхар тооцоо хийгдэж, 40 хувийн цалингийн нэмэгдэл нь нэг минутад ногдох цалингийн зардал нэмэгдэх үндэслэл болж байна.

<sup>7</sup> Эрүүл мэндийн үзүүлэлт 2013, хуудас 47

## ХҮСНЭГТ 2. СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	2011 он	2012 он	2013 он
	Сумын эмнэлэг		
Эмнэлгийн орны тоо	2928	2950	2971
Их эмчийн тоо	576	582	611
Сувилагчийн тоо	1341	1345	1383
Дундаж ор хоног	8.0	7.1	7.3
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо	109.720	104.663	101.010
Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо	2.009.293	2.002.007	1.910.213
Сум дундын эмнэлэг			
Эмнэлгийн орны тоо	675	658	661
Их эмчийн тоо	171	192	208
Сувилагчийн тоо	243	258	256
Дундаж ор хоног	7.8	8.9	7.0
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо	22.905	22.720	21.816
Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо	427.516	427.686	438.021

Сумын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийн үзүүлэлтээс харахад орны тоо нэмэгдсэн боловч хэвтүүлэн эмчлүүлэгч болон, амбулаториор үйлчлүүлэгчийн тоо буурсан, сум дундын эмнэлэгт хэвтүүлэн эмчлүүлэгчийн тоо бага зэрэг буурсан, амбулаториор эмчлүүлэгч бага зэрэг өссөн байна. Харин их эмчийн тоо өссөн үзүүлэлттэй байна.

### 3.1.2. Сумын эрүүл мэндийн төвийн төсвийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүд

Сумын эрүүл мэндийн төвийн өртөг тооцох, өртгийн судалгаан дээр үндэслэн төсвийн төсөөлөл хийхэд орцын буюу нөөцийн үзүүлэлтүүд чухал юм. Энэхүү тооцооллыг хийхдээ сумын эрүүл мэндийн төвийн төсвийн төсөл болон гүйцэтгэлд дүн шинжилгээ хийсэн.

Ингэхдээ цалин авдаг ажилтан тус бүрээр цалингийн зардлыг, эмийн зардлыг төсөвт суулгасан эмийн зардал дээр олон улсын донор, хандивлагч байгууллага, эмийн эргэлтийн сангийн санхүүгийн тоо баримтыг авч ашигласан.

Эдгээр зардлыг тооцохдоо шууд материал, шууд хөдөлмөрийн зардалд оруулж тооцсон бол бусад зардлыг тогтмол зардал буюу “Үйлдвэрийн нэмэгдэл зардал”-аар тооцов.

Сумын эрүүл мэндийн төв нь хувьсах зардлаа эрсдэл тооцсон нэг иргэнээр, тогтмол зардлаа зардлын зүйл ангиар төсөвлөн санхүүжилт авдаг (СЭМТ-ийн санхүүгийн гүйцэтгэлийн бүтэц санхүүгийн тайланг хүснэгт 3-аас харна уу).

Мөн Монголын мянганы сорилын сангийн халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийн хэрэгслүүд, НҮБ-ын Хүн амын сангийн жирэмслэлт, нөхөн үржихүйн хэрэгслийг үнэ төлбөргүй өгснийг шууд материалын зардалд нэмж тооцсон.

### ХҮСНЭГТ 3. 2012 ОНЫ СЭМТ-ИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ДУНДЖААР(ТӨГРӨГ)<sup>8</sup>

№	Үзүүлэлт	Төсөв	Гүйцэтгэл
1	Нийт зардал	195,878,700.00	195,290,599.10
2	Бараа, үйлчилгээний зардал	195,677,000.00	195,121,899.10
3	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	132,137,700.00	132,137,700.00
4	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,535,100.00	14,535,100.00
5	Хоол	4,100,000.00	4,100,000.00
6	Эм	10,131,000.00	9,793,547.10
7	Хөтөлбөр болон төслийн дотоод урсгал зардал	3,550,000.00	3,550,000.00

Хүснэгтээс дүгнэхэд нийт зардлын 67.4 хувийг цалингийн зардал, 10,3 хувийг цахилгаан, түлш халаалтын зардал, 5.1 хувийг эмийн зардал тус тус эзэлж байна. Эмийн зардал нийт төсвийн 5.1 хувийг эзэлж байгаа бол нэг ор хоногт 3486.2 төгрөгийн эм хэрэглэсэн байна.

<sup>8</sup> СЭМТ-ийн санхүүгийн гүйцэтгэлийн тайлангийн нэгтгэл, 2012 он



Сумын эрүүл мэндийн төвийн дундаж ор хоногийг 8 хоногоор тооцон, дээрх зардал дээр тооцоолоход нэг ор хоногт 1,410.0 төгрөгийн хоол ногдож байна. СЭМТ-ийн санхүүгийн гүйцэтгэлийн тайлангаас харахад СЭМТ-ийн төсөв нь 180-240 сая төгрөгийн хооронд хэлбэлзэж байна.

Төсөв их, бага байхад нөлөөлж буй хүчин зүйл нь эрүүл мэндийн төвийн хүний нөөц, алслагдсан байдал, тусламж, үйлчилгээний онцлог, хүн амын насны бүтцээс хамаарч байна. Насны бүтцийн хамаарлаас шалтгаалан төсвөөс олгож байгаа зардал харилцан адилгүй байна. Өртгийн төвийг сонгохдоо сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний багцад тусгагдсан, дийлэнх олонх тохиолддог өвчний тохиолдлоор, амбулатор, хэвтүүлэн эмчлэх, нийгмийн эрүүл мэндийн гэж ангилан тооцсон.

### БҮЛЭГ 3.2. I ЗЭРЭГЛЭЛИЙН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ

#### 3.2.1. I зэрэглэлийн СЭМТ-ийн амбулаторын тусламж үйлчилгээний өртөг

I зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төв нь аймгийн төвөөс 50 км дотор алслагдсан, аймгийн нэгдсэн эмнэлэгт хамгийн ойр сум юм.

I зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төвд халдвартын, эхийн амрах байр, ажиглалтын цөөн ороор хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ үзүүлж, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд ихэнх үйл ажиллагаагаа чиглүүлэх шаардлагатай гэж АХБ-ны зөвлөх GVG баг зөвлөсөн байдаг.

Бид судалгаандаа I зэрэглэлийн СЭМТ-ийн амбулаторын тусламж үйлчилгээгээр үзүүлэх 14 өвчнийг өртгийн төв тооцлоо. Өвчнийг сонгохдоо өртгийн төвийг үндэслэл сайтай тооцох боломж бүхий, мөн дийлэнх олонх тохиолдох байдлыг харгалзан авч үзлээ.

#### ХҮСНЭГТ 4. I ЗЭРЭГЛЭЛИЙН СЭМТ-ИЙН АМБУЛАТОРЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ /ТӨГ/

№	Тусламж үйлчилгээний өртгийн төв	Цалин зардал	Нийт зардалд эзлэх хувь	Эм,эмнэлгийн хэрэгсэл	Нийт зардалд эзлэх хувь	Тогтмол зардал	Нийт зардалд эзлэх хувь	Нийт зардал
1	Уушигны гуурсан хоолойн цочмог үрэвсэл	6,780	42.5	4,895	30.7	4,290	26.8	15,965
2	Нүдний салстын үрэвсэл	7,178	46.9	3,447	22.5	4,680	30.6	15,305
3	Толгой таллаж өвдөх	8,288	55.5	1,443	9.7	5,200	34.8	14,931
4	Хамар, залгиурын хурц үрэвсэл	5,120	43.9	3,155	27.1	3,380	29.0	11,655
5	Уушигны цочмог хатгалгаа	4,754	44.3	2,466	23.0	3,510	32.7	10,730
6	Залгиурын хурц үрэвсэл	4,250	40.5	3,763	35.9	2,470	23.6	10,483
7	Арьсны буглаа	2,448	24.7	4,721	47.7	2,730	27.6	9,899
8	Суулгалт	3,780	46.9	1,938	24.1	2,340	29.0	8,058
9	Артери даралт ихсэлт	3,783	47.8	238	3.0	3,900	49.2	7,921
10	Сургуульд элсэгчдийн үзлэг	4,490	56.7	1,215	15.4	2,210	27.9	7,915
11	Дунд чихний идээт үрэвсэл	3,410	43.6	2,723	34.8	1,690	21.6	7,823
12	Хамуу	2,937	41.7	2,152	30.6	1,950	27.7	7,039
13	Дунд чихний хурц үрэвсэл	2,241	34.9	1,453	22.6	2,730	42.5	6,424
14	Томуу	2,152	41.5	1,469	28.4	1,560	30.1	5,181
<b>Дундаж</b>		<b>4,869</b>	<b>43.7</b>	<b>2,865</b>	<b>25.4</b>	<b>3,390</b>	<b>30.9</b>	<b>10,718</b>

I зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төвийн амбулаторын тусламж үйлчилгээний өртгийн төвөөр сонгосон 14 өвчинд зарцуулагдах цалингийн зардлын дундаж нь


4,869 төгрөг, эм,эмнэлгийн хэрэгслийн дундаж зардал нь 2,865 төгрөг, тогтмол зардлын дундаж нь 3,390 төгрөг байна.

Хувиар авч үзвэл нэг өртгийн төвд зарцуулж буй зардалд дунджаар 44.0% нь цалинд, эм, эмнэлгийн хэрэгсэлд 25.0% нь, тогтмол зардал 31.0% -ийг тус тус эзэлж байна.

I зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төвийн амбулаторын зардал, өртгийн төвөөр сонгосон 13 өвчний дунджаар 10,718 төгрөг болж байгаа ба 5.181-15,965 төгрөгний хооронд хэлбэлзэж байна.

Амбулаторын тусламж, үйлчилгээний тогтмол зардал цалингийн зардлаас ойролцоогоор 2.2 дахин, эм, эмнэлгийн хэрэгслийн зардлаас 3.2 дахин их байна.

### ДҮРСЛЭЛ 3. I ЗЭРЭГЛЭЛИЙН СЭМТ-ИЙН АМБУЛАТОРЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ



Өвчнөөр авч үзвэл амбулаториор толгой таллаж өвдөх өвчтэй 1 үйлчлүүлэгчдэд зарцуулах цалингийн дундаж өртөг 8,288 төгрөг байгаа нь хамгийн өндөр, томуу өвчин 2,152 төгрөг буюу өртөг нь хамгийн бага байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хувьд гуурсан хоолойн хурц үрэвсэл өвчтэй 1 үйлчлүүлэгчдэд 4,895 төгрөг зарцуулж байгаа нь хамгийн өндөр бол, артерийн даралт ихсэлтэд 238 төгрөг зарцуулж байгаа нь хамгийн бага байна.

Тогтмол зардлаар (1 үйлчлүүлэгчдэд зарцуулах хугацаагаар авсан зардал) авч үзвэл толгой таллаж өвдөх өвчтэй 1 үйлчлүүлэгчдэд 5,200 төгрөг зарцуулж байгаа нь хамгийн өндөр, томуу өвчинд 1,560 төгрөг зарцуулж байгаа нь хамгийн бага байна. Нийт зардлаар авч үзвэл гуурсан хоолойн хурц үрэвсэлтэй өвчин хамгийн өндөр өртөгтэй нь, томуу өвчин хамгийн бага өртөгтэй нь болж байна.

Сумын эрүүл мэндийн төвийн өрхийн эрүүл мэндийн төвөөс ялгарах онцлог нь яаралтай түргэн тусламж үйлчилгээг үзүүлдэг.

### ХҮСНЭГТ 5. I ЗЭРЭГЛЭЛИЙН СЭМТ-ИЙН ЯАРАЛТАЙ ТҮРГЭН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ /ТӨГ/

№	Тусламж үйлчилгээний өртгийн төв	Цалингийн зардал	Эм, эмнэлгийн хэрэгслийн зардал	Шатахууны зардал	Нийт зардал
1	Артерийн даралт ихдэлт	13,460	1,560	11,900	26,920
2	Мухар олгойн хурц үрэвсэл	9,642	1,545	16,450	27,637
3	Хатгаа	8,540	571	8,400	17,511
4	Осол гэмтэл	10,460	4,256	12,950	33,300
5	Манас таталт	9,320	855	16,800	30,305
	Дундаж өртөг	10,284.4	5,259.2	13,300.0	28,843.6

I зэрэглэлийн СЭМТ-ийн яаралтай тусламж, үйлчилгээний цалингийн зардлын дундаж 10284.4 төгрөг, эм, эмнэлгийн хэрэгслийн зардлын дундаж 5259.2 төгрөг, шатахууны зардлын дундаж нь 13300.0 төгрөг байна. Цалингийн зардал яаралтай тусламж үйлчилгээнд явсан ажиллагсдын зарцуулсан хугацаанаас, шатахууны зардал нь дуудлаганд явсан зай (алслагдсан байдал)-аас хамаарч байна.

### 3.2.2. I зэрэглэлийн СЭМТ-ийн хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний өртөг

I зэрэглэлийн суманд яаралтайгаас бусад үед эхийг төрүүлэхгүй, мөн хурц, яаралтай тусламж, үйлчилгээ авах тохиолдолд аймгийн нэгдсэн эмнэлэгт хүргэдэг. Монгол улсын хэмжээнд I зэрэглэлд 17 сумын эрүүл мэндийн төвийг хамааруулан авч үздэг.

Бид судалгаандаа I зэрэглэлийн СЭМТ-ийн хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээгээр үзүүлэх 11 өвчинг сонгон өртгийг тооцлоо.

## ХҮСНЭГТ 6. I ЗЭРЭГЛЭЛИЙН СЭМТ-ИЙН ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ /ТӨГ/


№	Тусламж үйлчилгээний өртгийн төв	Цалингийн зардал	Нийт зардалд эзлэх хувь	Эм, эмнэлгийн хэрэгслийн зардал	Нийт зардалд эзлэх хувь	Тогтмол зардал	Нийт зардалд эзлэх хувь	Нийт зардал
1	Дунд чихний идээт үрэвсэл	46,246	34.9	24,509	18.5	61,810	46.6	132,565
2	Толгой өвдөх	35,763	27.1	34,204	26.0	61,810	46.9	131,777
3	Толгой таллаж өвдөх	39,644	31.5	24,560	19.5	61,810	49.1	126,014
4	Гуурсан хоолойн цочмог үрэвсэл	47,153	38.2	14,520	11.8	61,810	50.1	123,483
5	Артерийн даралт ихсэн өвчин	41,432	34.4	16,620	14.4	61,810	51.2	119,862
6	Төмөр дутлын цус багадаг	45,650	34.6	11,320	13.9	61,810	51.6	118,780
7	Дунд чихний идээт үрэвсэл	38,640	38.4	17,680	9.5	61,810	52.0	118,130
8	Нүдний салстын өвчин	31,265	32.7	21,320	15.0	61,810	52.3	114,395
9	Томуу	27,540	27.3	21,507	18.6	61,810	54.0	110,857
10	Арьсны буглаа, хатиг	31,749	24.8	16,450	19.4	61,810	55.8	110,009
11	Уушигны цочмог хатгалгаа	33,455	28.9	14,325	15.0	61,810	56.2	109,590
	Дундаж	38,049	32.1	19,729	16.5	61,810	51.5	119,588

I зэрэглэлийн СЭМТ-ийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний цалингийн зардлын дундаж зардал 38,049 төгрөг, эм, эмнэлгийн хэрэгслийн дундаж зардал 19,729 төгрөг, тогтмол зардал нь бүх үйлчлүүлэгчдэд 8 хоногийн ор хоногоор тооцож авахад, дунджаар 61,810 төгрөг байна.

Хувиар авч үзвэл дундаж цалин 32.1%, эмнэлгийн хэрэгсэл 16.5%, тогтмол зардал 52.5 хувийг тус тус эзэлж байна.

I зэрэглэлийн эрүүл мэндийн төвийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний тогтмол зардал цалингийн зардлаас ойролцоогоор 1.6 дахин, эм, эмнэлгийн хэрэгслийн зардлаас 3.1 дахин их байна.

#### ДҮРСЛЭЛ 4. I ЗЭРЭГЛЭЛИЙН СЭМТ-ИЙН ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ



I зэрэглэлийн сумын эрүүл мэндийн хэвтүүлэн эмчлэх зардал, өртгийн төвөөр сонгосон 11 өвчний дунджаар 119,588 төгрөг болж байгаа ба 109,588-132585 төгрөгний хооронд хэлбэлзэж байна. Бүх өвчний тохиолдлыг эмчлэх дундаж ор хоногийг 8 хоногоор авсан ба нэг хоногт зарцуулах тогтмол зардлын дунджаар үржүүлж тооцов. Нийт тогтмол зардал 61,810 төгрөг зарцуулж байна.

Өвчнөөр авч үзвэл хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний, дунд чихний идээт үрэвсэлтэй 1 эмчлүүлэгчдэд 46, 248 төгрөгний цалингийн зардал ногдож байгаа нь хамгийн өндөр, томуу өвчинд 27,540 төгрөг ногдож байгаа нь хамгийн бага байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хувьд толгой өвдөх өвчин хамгийн өндөр (34,204 төгрөг), төмөр дутлын цус багадалт өвчин (11,320 төгрөг) хамгийн бага өртөгтэй байна. Нэг хэвтүүлэн эмчлүүлэгчид зарцуулж буй нийт өртөгийг 8 ор хоногоор тооцон авч үзвэл:

Дунд чихний идээт үрэвсэл өвчин хамгийн өндөр өртгөөр, уушигны хатгаа өвчин хамгийн бага өртгөөр эмчлэгдэж байна.

### БҮЛЭГ 3.3. II ЗЭРЭГЛЭЛИЙН СЭМТ-ИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ

#### 3.3.1. II зэрэглэлийн СЭМТ-ийн амбулаторын тусламж үйлчилгээний өртөг

II зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төв нь аймгийн төвөөс 100 км дотор алслагдсан сумын эмнэлэг юм. Ангилалаар II зэрэглэл 89 эрүүл мэндийн төв ордог.

II зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төвийн амбулаториор эмчлэх 16 өвчнийг өртөгийн төвөөр авлаа. Өртөгийн төвийг сонгохдоо I зэрэглэлийн аргачлалтай ижил, өөрөөр хэлбэл дийлэнх олонх тохиолддог, өртгийн тооцоодлол хийхэд бодит мэдээлэл сайтай гэж үзсэн болно.

### ХҮСНЭГТ 7. II ЗЭРЭГЛЭЛИЙН СЭМТ-ИЙН АМБУЛАТОРЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ /ТӨГ/


№	Тусламж үйлчилгээний өртгийн төв	Цалин зардал	Нийт зардалд эзлэх хувь	Эм,эмнэлгийн хэрэгсэл	Нийт зардалд эзлэх хувь	Тогтмол зардал	Нийт зардалд эзлэх хувь	Нийт зардал
1	Төрөлтийн 3-р үеийн цус алдалт	5,700	22.6	2,720	10.7	16,900	66.7	25,320
2	Жирэмсний эрт үед цус алдах	6,764	34.5	1,270	6.5	11,570	59.0	19,604
3	Цус харвалт	5,928	30.5	3,170	16.8	10,140	52.7	19,238
4	Төвөнх, цагаан мөгөөрсөн хоолойн цочмог үрэвсэл	4,864	35.4	545	4.0	8,320	60.6	13,729
5	Цочмог цөсний хүүдийн үрэвсэл	3,572	28.9	2,680	21.7	6,110	49.4	12,362
6	Нүүр толгой ба хүүзүүний булчирхайн цочмог үрэвсэл	4,104	34.0	975	8.0	7,020	58.0	12,099
7	Цочмог нефритийн хам шинж	4,028	34.5	760	6.5	6,890	59.0	11,678
8	Арьсны атопик үрэвсэл	3,724	33.2	1,130	10.1	6,370	56.7	11,224
9	Салхин цэцэг	3,572	32.4	1,350	12.2	6,110	55.4	11,032
10	Хамрын дайврын архаг үрэвсэл	3,192	29.0	2,356	21.4	5,460	49.6	11,008
11	Цагаан хорхой	3,344	33.8	840	8.5	5,720	57.7	9,904
12	Цөсний чулуу	2,812	30.0	1,780	19.0	4,810	51.0	9,402
13	Хамрын дайврын цочмог үрэвсэл	2,736	30.0	1,740	19.0	4,680	51.0	9,156
14	Хөхний тодорхойгүй үүсгэвэр	3,040	34.4	608	6.8	5,200	58.8	8,848
15	Гадна чихний буглаа	2,280	27.4	2,150	25.8	3,900	46.8	8,330
16	Сульдаа	2,508	34.6	570	7.9	4,160	57.5	7,238
<b>Дундаж</b>		<b>3,886</b>	<b>31.7</b>	<b>1,540</b>	<b>12.7</b>	<b>7,085</b>	<b>55.6</b>	<b>12,511</b>

II зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төвийн амбулаторын тусламж үйлчилгээний өртгийн төвөөр сонгосон 16 өвчинд зарцуулагдах цалингийн зардлын дундаж нь 3,836 төгрөг, эм,эмнэлгийн хэрэгслийн дундаж зардал нь 1,540 төгрөг, тогтмол зардлын дундаж нь 7,085 төгрөг байна.

Хувиар авч үзвэл 1 өртгийн төвд дунджаар цалинд 31.0%, эм эмнэлгийн хэрэгсэлд 13.0%, тогтмол зардалд 56.0% зарцуулж байна.

Амбулаторын тусламж, үйлчилгээний тогтмол зардал цалингийн зардлаас ойролцоогоор 3.2 дахин, эм, эмнэлгийн хэрэгслийн зардлаас 1.8 дахин их байна.

## ДҮРСЛЭЛ 5. II ЗЭРЭГЛЭЛИЙН СЭМТ-ИЙН АМБУЛАТОРЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ



II зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төвийн амбулаторын зардал, өртгийн төвөөр сонгосон 16 өвчний дунджаар 12, 511 төгрөг болж байгаа ба 7,238-25320 төгрөгний хооронд хэлбэлзэж байна.

II зэрэглэлд өвчнөөр авч үзвэл амбулаториор жирэмсэний эрт үеийн цус алдах оноштой 1 эмчлүүлэгчдэд 6,764 төгрөгний цалингийн зардал ногдож байгаа нь хамгийн өндөр, сульдаа өвчинд 2,508 төгрөг ногдож байгаа нь хамгийн бага байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хувьд төрөлтийн 3-р үеийн цус алдалт өвчтэй 1 үйлчлүүлэгчдэд 2,720 төгрөг зарцуулж байгаа нь хамгийн өндөр, сульдаад 570 төгрөг зарцуулж байгаа нь хамгийн бага байна.

Тогтмол зардлаар авч үзвэл мөн төрөлтийн 3-р үеийн цус алдалт өвчинд 16,900 төгрөг зарцуулж байгаа нь хамгийн өндөр, гадна чихний буглаа өвчинд 3,900 төгрөг зарцуулж байгаа нь хамгийн бага байна. II зэрэглэлд нийт дүнгээрээ амбулаторт хамгийн бага өртгийн төв нь сульдаа өвчин, хамгийн өндөр өртгийн төв нь төрөлтийн 3-р үеийн цус алдалт байна.

### ХҮСНЭГТ 8. II зэрэглэлийн СЭМТ-ийн яаралтай тусламж, үйлчилгээ(алсын дуудлага)-ний өртөг /төг/

№	Тусламж үйлчилгээний өртгийн төв	Цалингийн зардал	Эм, эмнэлгийн хэрэгсэл	Шатахууны зардал	Нийт зардал
1	Артерийн даралт ихдэлт	12,645	2,412	17,500	32,557
2	Мухар олгойн хурц үрэвсэл	18,460	1,625	19,250	39,335
3	Хатгаа	9,785	875	16,625	27,285
4	Осол гэмтэл	13,984	5,255	17,500	36,739
5	Манас таталт	12,544	985	14,525	28,054
Дундаж		13,483.6	2,230.4	17,080.0	32,794.0

II зэрэглэлийн СЭМТ-ийн яаралтай тусламжийн өртгийн цалингийн зардлын дундаж нь 13483.6 төг, эм, эмнэлгийн хэрэгслийн дундаж нь 2230,4 төгрөг, шатахууны зардлын дундаж нь 17080.4 төг, нийт зардлын дундаж нь 31794.0 төг тус тус байна.



**3.3.2. II зэрэглэлийн СЭМТ-ийн стационарын тусламж үйлчилгээний өртөг**

Бид судалгаандаа II зэрэглэлийн СЭМТ-ийн хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ үзүүлсэн зонхилон тохиолддог 14 өвчинг өртгийн төв болгон тооцлоо.

**ХҮСНЭГТ 9. II ЗЭРЭГЛЭЛИЙН СЭМТ-ИЙН ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ /ТӨГ/**

№	Тусламж үйлчилгээний өртгийн төв	Цалингийн зардал	Нийт зардалд эзлэх хувь	Эм, эмнэлгийн хэрэгслийн зардал	Нийт зардалд эзлэх хувь	Тогтмол зардал	Нийт зардалд эзлэх хувь	Нийт зардал
1	Гадна чихний буглаа	34,200	24.1	35,548	25.0	72,315	50.9	142,063
2	Хамрын дайврын цочмог үрэвсэл	34,656	25.0	31,450	22.7	72,315	52.3	138,421
3	Цус харвалт	23,484	17.3	39,650	29.3	72,315	53.4	135,449
4	Салхин цэцэг	28,500	21.5	31,454	23.8	72,315	54.7	132,269
5	Төрөлтийн 3-р үеийн цус алдалт	39,480	31.2	14,562	11.5	72,315	57.3	126,357
6	Цөсний чулуу	23,940	19.1	29,454	23.4	72,315	57.5	125,709
7	Хамрын дайврын архаг үрэвсэл	27,056	21.8	24,556	19.8	72,315	58.4	123,927
8	Арьсны атопик үрэвсэл	21,360	18.0	25,319	21.3	72,315	60.7	118,994
9	Цочмог цөсний хүүдийн үрэвсэл	20,444	17.2	25,870	21.8	72,315	61.0	118,629
10	Жирэмсний эрт үед цус алдах	32,450	27.6	13,465	11.3	72,315	61.1	118,230
11	Цочмог нефритийн хам шинж	18,240	15.5	27,348	23.2	72,315	61.3	117,903
12	Нүүр толгой ба хүзүүний булчирхайн цочмог үрэвсэл	26,750	23.9	12,873	11.5	72,315	64.6	111,938
13	Төвөнх, цагаан мөгөөрсөн хоолойн цочмог үрэвсэл	21,640	20.5	11,478	10.9	72,315	68.6	105,433
14	Хөхний тодорхойгүй үүсвэр	17,640	18.5	5,678	5.9	72,315	75.6	95,633
	<b>Дундаж</b>	<b>26,417</b>	<b>21.5</b>	<b>23,479</b>	<b>18.7</b>	<b>72,315</b>	<b>59.8</b>	<b>122,211</b>


II зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төвийн хэвтүүлэн эмчлэх эмчилгээний зардал, өртгийн төвөөр сонгосон 14 өвчний дунджаар 122,211 төгрөг болж байгаа ба 96,633-412,063 төгрөгийн хооронд хэлбэлзэж байна.

II зэрэглэлийн СЭМТ-ийн хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний цалингийн зардал дунджаар 26,417 төгрөг, эм, эмнэлгийн хэрэгслийн зардал дунджаар 23,479 төгрөг, тогтмол зардал нь дунджаар 72,315 төгрөг байна.

Хувиар авч үзвэл дунджаар цалин 21.5%, эм, эмнэлгийн хэрэгсэл 18.7%, тогтмол зардал 59.8% эзэлж байна. Энэ нь хэвтэн эмчлүүлэгчийн эмчилгээний зардлын дийлэнх хувь нь тухайн сумын эрүүл мэндийн төвийн барилга, түлш, халаалт болон захиргаа, аж ахуйн зардалд зарцуулагдаж байгааг харуулж байна.

Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний тогтмол зардал цалингийн зардлаас ойролцоогоор 2.7 дахин, эм, эмнэлгийн хэрэгслийн зардлаас 3.0 дахин их байна.

## ДҮРСЛЭЛ 6. II ЗЭРЭГЛЭЛИЙН СЭМТ-ИЙН ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ



II зэрэглэлийн СЭМТ-ийн нэг хэвтүүлэн эмчлүүлэгчид зарцуулж буй нийт өртгийг 8 ор хоногоор тооцон авч үзвэл:

- Хамгийн өндөр өртгийн төв нь гадна чихний буглаа өвчин (34,200), хамгийн бага өртгийн төв нь хөхний тодорхойгүй үүсвэр өвчин (17,640) байна.
- Мөн хамгийн бага эм, эмнэлгийн хэрэгслийн зардал хөхний тодорхойгүй үүсвэр өвчин дээр (5,670 төг), хамгийн өндөр зардал (35,548 төг) гадна чихний буглаа өвчин орж байна.
- Тогтмол зардал 72,315 төгрөг байна.

### БҮЛЭГ 3.4 III ЗЭРЭГЛЭЛИЙН СЭМТ-ИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ

#### 3.4.1. III зэрэглэлийн СЭМТ-ийн амбулаторын тусламж үйлчилгээний өртөг

III зэрэглэлийн СЭМТ-д аймгийн төвөөс 100 км-ээс дээш зайд алслагдсан сумын эрүүл мэндийн төвүүд орно. Ангиллаар III зэрэглэл 204 эрүүл мэндийн төв ордог.

III зэрэглэлийн СЭМТ нь аймгийн төвөөс алслагдсан, төрөлжсөн мэргэжлийн эмчтэй, зарим мэс засал, мэс ажилбар хийх, яаралтай үед тусламж үйлчилгээ үзүүлдэг, Мэс заслын ортой, төрөлжсөн мэргэжлийн оношилгоо, эмчилгээний багаж тоног төхөөрөмжөөр хангагдсан байдаг.

Сумын эрүүл мэндийн төвийн санхүүжилтийн бүтцийг авч үзэхэд цалингийн зардал 55-65 хувьтай, эм, хоол, эмчилгээний зардал 20-25 хувьтай, үлдсэн нь тогтмол болон бензин шатахуун, захиргааны зардал ногдож байна.

**ХҮСНЭГТ 10. III ЗЭРЭГЛЭЛИЙН СЭМТ-ИЙН АМБУЛАТОРЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ /ТӨГ/**


№	Тусламж үйлчилгээний өртгийн төв	Цалингийн зардал	Нийт зардалд эзлэх хувь	Эм,эмнэлгийн хэрэгслийн зардал	Нийт зардалд эзлэх хувь	Тогтмол зардал	Нийт зардалд эзлэх хувь	Нийт зардал	Нийт зардалд эзлэх хувь
1	Цочмог В гепатит	5,116	29.93%	4,650	27.20%	7,330	42.88%	17,097	100%
2	Толгой эргэх ба дүйнгэтэх	4,660	27.26%	5,412	31.65%	6,550	41.09%	16,623	100%
3	Нойрны хямрал	4,736	16.00%	4,340	13.69%	6,680	70.31%	15,756	100%
4	Тархины цус багадах дайрал	4,812	28.15%	3,783	22.13%	6,810	49.73%	15,406	100%
5	Биеийн юмны мөчлөгийн үеийн өвдөлт	4,584	26.81%	3,982	23.29%	6,420	49.90%	14,987	100%
6	Умайн гаднах жирэмслэлт	4,736	27.70%	3,455	20.21%	6,680	52.09%	14,871	100%
7	Кандидоз	4,584	26.81%	3,632	21.24%	6,420	51.94%	14,636	100%
8	Бөөрний даралт ихсэх өвчин	4,508	26.37%	3,148	18.41%	7,290	55.22%	14,946	100%
9	Түрүү булчирхайн үрэвсэлт өвчин	3,356	19.63%	4,436	25.95%	5,030	54.42%	12,822	100%
10	Архины шалтгаант элэгний өвчин	3,900	22.81%	5,565	32.55%	5,250	44.64%	14,716	100%
11	Глаукома	2,950	17.26%	4,542	26.57%	4,250	56.18%	11,742	100%
12	Эпилепсия	4,128	24.15%	3,724	21.78%	5,640	54.07%	13,492	100%
13	Зүрхний цочмог шигдээс	3,973	23.24%	2,898	16.95%	5,380	59.81%	12,251	100%
14	Бруцеллөз	3,944	23.07%	3,971	23.23%	5,120	53.70%	13,035	100%
15	Багтраа	5,824	34.07%	3,870	22.64%	5,120	43.30%	14,815	100%
16	Ревматоид артрит	3,672	21.48%	3,788	22.16%	4,860	56.37%	12,320	100%
17	Цэвэршилт ба цэвэршилт тойрсон хямрал	3,368	19.70%	4,341	25.39%	4,340	54.91%	12,049	100%
18	Чихрийн шижингийн 1-р хэлбэр	3,444	20.15%	4,123	24.12%	4,470	55.74%	12,037	100%
19	Гүйлсэн булчирхай орчмын буглаа	3,596	21.03%	3,560	20.82%	4,730	58.14%	11,886	100%
20	Өндгөвчний үйл ажиллагааны хямрал	3,292	19.26%	4,342	25.40%	4,220	55.35%	11,854	100%
21	Харшлын ринит	3,292	19.26%	4,203	24.58%	4,210	56.16%	11,705	100%
22	Мастойдит	3,824	22.37%	2,454	14.35%	5,120	63.28%	11,398	100%
23	Цочмог бронхиолит	3,368	19.70%	3,357	19.64%	4,340	60.66%	11,065	100%
24	Цочмог панкреатит	3,140	18.37%	3,655	21.38%	3,950	60.26%	10,745	100%
<b>Дундаж</b>		<b>4,034</b>	<b>23.1%</b>	<b>3,968</b>	<b>22.72%</b>	<b>5,425</b>	<b>54.17%</b>	<b>13,427</b>	<b>100%</b>

III зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төвийн амбулаторын тусламж үйлчилгээний өртгийн төвөөр сонгосон 24 өвчинд зарцуулагдах:

- Цалингийн дундаж зардал нь 4, 033 төгрөг
- Эм, эмнэлгийн хэрэгслийн дундаж зардал нь 3,968 төгрөг
- Тогтмол зардал нь дунджаар 5,425 төгрөг байна.

Хувиар авч үзвэл дунджаар цалин 23.1%, эмнэлгийн хэрэгсэл 22.72%, тогтмол зардал 54.17% эзэлж байна.

### ДҮРСЛЭЛ 7. III ЗЭРЭГЛЭЛИЙН СЭМТ-ИЙН АМБУЛОТОРЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ



III зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төвийн амбулаторын эмчилгээний өртгийн төвөөр сонгосон 24 өвчний дундаж өртөг 7,420,9 төгрөг болж, 4,746-10,897 төгрөгний хооронд хэлбэлзэж байна.

III зэрэглэлд, өвчнөөр авч үзвэл амбулаториор В вируст элэгний цочмог үрэвсэл оноштой 1 эмчлүүлэгчдэд 3,116 төгрөгний цалингийн зардал ногдож байгаа нь хамгийн өндөр, нойр булчирхайн хурц үрэвсэл өвчинд 1,140 төгрөг байгаа нь хамгийн бага байна. Эм, эмнэлгийн хэрэгслийн хувьд толгой эргэх ба дүйнгэтэх өвчтэй 1 үйлчлүүлэгчдэд 3,412 төгрөг зарцуулж байгаа нь хамгийн өндөр, чихний хөхлөг сэртэнгийн үрэвсэл өвчинд 454 төгрөг зарцуулж байгаа нь хамгийн бага байна.

Тогтмол зардлаар авч үзвэл В вируст элэгний цочмог үрэвсэл өвчинд 5,530 төгрөг зарцуулж байгаа нь хамгийн өндөр, нойр булчирхайн хурц үрэвсэл өвчинд 1,950 төгрөг зарцуулж байгаа нь хамгийн бага байна.

**Хүснэгт 11. III зэрэглэлийн СЭМТ-ийн яаралтай тусламж, үйлчилгээний (алсын дуудлага)-ний өртөг /төг/**

№	Тусламж үйлчилгээний өртгийн төв	Цалингийн зардал	Эм, эмнэлгийн хэрэгсэл	Шатахууны зардал	Нийт зардал
1	Артерийн даралт ихдэлт	14,070	3,654	24,528	42,252
2	Мухар олгойн хурц үрэвсэл	22,019	1,752	21,024	44,795
3	Хатгаа	12,143	915	19,128	32,186
4	Осол гэмтэл	15,240	6,890	19,856	41,986
5	Манас таталт	13,545	5,236	18,254	37,035
Дундаж		15,403.4	3,689.4	20,558.0	39,650.8

III зэрэглэлийн СЭМТ-ийн яаралтай, тусламж, үйлчилгээний өртгийн цалингийн зардлын дундаж 15403.4 төг, эм, эмнэлгийн хэрэгслийн зардлын дундаж 3689.4 төг, шатахууны зардлын дундаж нь 20558.0 төг, нийт зардлын дундаж 39650.8 төг тус тус байна. Яаралтай тусламж үйлчилгээний хамгийн өндөр зардал нь шатахууны зардал байна. СЭМТ-ийн яаралтай тусламжийн машин дунджаар жилд 28,000-30,000 км зам явахаар тооцож, сэлбэг хэрэгсэл, шатахууныг төсөвлөдөг байна.

**3.4.2. III зэрэглэлийн СЭМТ-ийн хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний өртөг**

Бид судалгаандаа III зэрэглэлийн СЭМТ-ийн хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ үзүүлсэн, зонхилон тохиолддог 22 өвчинг өртгийн төв болгон тооцлоо. III зэрэглэлийн СЭМТ нь хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээг үйлчлэх хүрээний хүн амд хүргэх эмнэлгийн ор, I, II зэрэглэлээсээ олон байхаар бодлогын чиглэл гараад байна. Анх төрж буй эмэгтэй, яаралтай аймгийн нэгдсэн эмнэлэгт хүргэх шаардлагатай өвчтөн зэрэгт шатахууны зардлыг хамгийн ихээр зарцуулдаг байна.

**ХҮСНЭГТ 12. III ЗЭРЭГЛЭЛИЙН СЭМТ-ИЙН ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ /ТӨГ/**

№	Тусламж үйлчилгээний өртгийн төв	Цалингийн зардал	Нийт зардалд эзлэх хувь	Эм, эмнэлгийн хэрэгслийн зардал	Нийт зардалд эзлэх хувь	Тогтмол зардал	Нийт зардалд эзлэх хувь	Нийт зардал
1	Гүйлсэн булчирхай орчмын буглаа	42,864	30.4	21,569	15.3	76,522	54.3	140,955
2	Тархины цус багадаа дайрал	39,064	28.1	23,540	16.9	76,522	55.0	139,126
3	Цочмог В гепатит	41,572	30.4	18,687	13.6	76,522	56.0	136,781
4	Бруцеллөз	34,200	25.3	24,654	18.2	76,522	56.5	135,376
5	Нойрны хямрал	37,696	28.1	19,876	14.8	76,522	57.1	134,094
6	Цочмог бронхилот	41,876	31.4	14,875	11.1	76,522	57.5	133,273
7	Бөөрний даралт ихсэх өвчин	39,140	29.5	16,789	12.7	76,522	57.8	132,451
8	Харшлын гаралтай хамрын үрэвсэл	39,864	30.1	15,980	12.0	76,522	57.9	132,366
9	Масдойдит	36,860	27.9	18,795	14.2	76,522	57.9	132,177
10	Уналт, таталт	44,080	33.5	11,254	8.5	76,522	58.0	131,856
11	Мөөгөнцөртөх өвчин	37,841	29.1	15,690	12.0	76,522	58.9	130,053
12	Толгой эргэх ба дүйнгэтэх	37,012	28.4	16,450	12.7	76,522	58.9	129,984
13	Түрүү булчирхайн үрэвсэлт өвчин	35,644	27.6	16,980	13.1	76,522	59.3	129,146
14	Архины шалтгаант элэгний өвчин	37,924	29.5	13,965	10.9	76,522	59.6	128,411
15	Нүдний даралт ихсэх өвчин	34,504	27.0	16,870	13.2	76,522	59.8	127,896
16	Нойр булчирхайн цочмог үрэвсэл	32,145	25.2	18,741	14.7	76,522	60.1	127,408
17	Чихрийн шижингийн 1-р хэлбэр	37,164	29.4	12,642	10.0	76,522	60.6	126,328
18	Багтраа	33,456	26.7	15,456	12.3	76,522	61.0	125,434
19	Цэвэршилт ба цэвэршилт тойрсон хямрал	34,732	28.0	12,545	10.2	76,522	61.8	123,799
20	Өндгөвчний үйл ажиллагааны хямрал	29,856	24.3	16,454	13.4	76,522	62.3	122,832
21	Үений хэрх төст үрэвсэл	27,968	23.1	16,890	13.9	76,522	63.0	121,380
22	Зүрхний цочмог шигдээс	24,568	20.7	17,841	15.0	76,522	64.3	118,931
Дундаж		36,365	27.9	17,116	13.1	76,522	59.0	130,003

III зэрэглэлийн СЭМТ-ийн хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний цалингийн зардал дунджаар 36,366 төгрөг (28 хувь) хооронд хэлбэлзэж байгаа бол, эм, эмнэлгийн хэрэгслийн зардал нь дунджаар 17,116 төгрөг (13 хувь), тогтмол зардал нь дунджаар 76,522 төгрөг (59.0 хувь) байна.

Хувиар авч үзвэл дунджаар цалин 27.9%, эм, эмнэлгийн хэрэгсэл 13.1%, тогтмол зардал 59.0% тус тус эзэлж байна.

Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний тогтмол зардал цалингийн зардлаас ойролцоогоор 2 дахин, эм, эмнэлгийн хэрэгслийн зардлаас 4,5 дахин их байна.

Аль ч зэрэглэлийн эрүүл мэндийн төвийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний тогтмол зардал өндөр байгаа нь (51.0%-60.0%) үйлчлэх хүрээний хүн ам цөөтэй, том барилга байгууламжтай, захиргааны зардал ихтэй байгаа нь нөлөөлж байна.

### ДҮРСЛЭЛ 8. III ЗЭРЭГЛЭЛИЙН СЭМТ-ИЙН ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ



III зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төвийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний өртгийн төвөөр сонгосон 22 өвчний дундаж өртөг 130,003 төгрөг болж, 118,931-140,955 төгрөгийн хооронд хэлбэлзэж байна.

III зэрэглэлийн СЭМТ-ийн нэг хэвтүүлэн эмчлүүлэгчид зарцуулж буй нийт өртгийг 8 ор хоногоор тооцон авч үзвэл:

- Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээнд гүйлсэн булчирхай орчмын буглаа хамгийн өндөр өртөгтэй, зүрхний цочмог шигдээс хамгийн бага өртөгтэй байна.
- Цалингаар авч үзвэл, хамгийн бага нь өртөгтэй нь зүрхний цочмог шигдээс 24,568 төгрөг, хамгийн өндөр нь эпилепси өвчин 44,080 төгрөг байна
- Эм, эмнэлгийн хэрэгслийн хамгийн өндөр зардалтай нь бруцеллэз өвчин 34,200 төгрөг, хамгийн бага нь уналт, таталт өвчин 11,254 төгрөгийн зардалтай байна.

#### 3.4.3. I.II.III зэрэглэлийн эрүүл мэндийн төвийн өртгийн төвийн ерөнхий төлөв

Сумын эрүүл мэндийн төвийн 3 зэрэглэл нь өөрийн гэсэн тусламж, үйлчилгээний онцлогтой, өртгийн төв нь харилцан адилгүй боловч нэг үйлчлүүлэгчдэд зарцуулах хугацаа, хэрэглэж буй эм, эмнэлгийн хэрэгсэл нь ойролцоо түвшинд учраас дундаж өртөг болон, өртгийн дээд, доод хязгаарыг нэг хүснэгтээр харьцуулан харуулав.



**ХҮСНЭГТ 13. I.II.III ЗЭРЭГЛЭЛИЙН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДУНДАЖ ӨРТӨГ**

Тусламж үйлчилгээний өртөгийн төв (тоо)	Цалин		Эм, эмнэлгийн хэрэгсэл		Тогтмол зардал		Нийт зардал	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
<b>Амбулаторын тусламж, үйлчилгээний өртөг (дундаж)</b>								
I зэрэглэл -14	4,869	43,7	2,865	25.4	3,390	30.9	10,718	100.0
II зэрэглэл -16	3,886	31.7	1,540	12.7	7,085	55.6	12,511	100.0
III зэрэглэл -24	4,034	23.6	3,968	23.21	5,425	56,2	13,427	100.0
<b>Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний өртөг (дундаж)</b>								
I зэрэглэл-11	38,049	32.1	19,729	16.5	61,810	51.5	119,588	100.0
II зэрэглэл- 14	26,417	21.5	23,479	18.7	72,315	59.8	122,211	100.0
III зэрэглэл -22	36,365	27.9	17,116	13.1	76,522	59.0	130,003	100.0

Аль ч зэрэглэлийн эрүүл мэндийн төвд тухайн өртгийн төвд ногдож буй цалин, тогтмол зардал тогтмол өндөр байна.

Амбулаторын тусламж, үйлчилгээнд цалингийн дундаж I зэрэглэлд хамгийн өндөр өртөг буюу II зэрэглэлээс 1.2 дахин, 2.4 дахин илүү байна. Харин II зэрэглэлд тогтмол зардал өндөр гарсан байна. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд I. II. III зэрэглэлд дундаж ор хоногийг ижилхэн 8 хоногоор тооцон, дундаж тогтмол зардлыг тооцоолоход I зэрэглэлд 61810 төгрөг байсан бол II зэрэглэлд 72315 төгрөг, III зэрэглэлд 76,522 байгаа ба зэрэглэл хооронд 4207-10505 төгрөгний буюу нэг их хол зөрөө бага байна.

**ХҮСНЭГТ 14. I.II.III ЗЭРЭГЛЭЛИЙН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДУНДАЖ ӨРТГИЙН ТӨВИЙН ДЭЭД, ДООД ХЯЗГААР**

Тусламж үйлчилгээний өртөгийн төв (тоо)	Цалин		Эм, эмнэлгийн хэрэгсэл		Тогтмол зардал		Нийт зардал	
	өндөр	бага	Өндөр	бага	өндөр	бага	өндөр	бага
<b>Амбулаторын тусламж, үйлчилгээний өртөг (дундаж)</b>								
I зэрэглэл -14	8,288	2,152	4,895	238	5,200	1,560	15966	5181
II зэрэглэл -16	6,764	2,280	2,720	570	16,900	3,900	25,320	7,238
III зэрэглэл -24	5,116	3,140	5,565	2454	7,330	3,950	17,097	10,745
<b>Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний өртөг (дундаж)</b>								
I зэрэглэл-11	47,153	27,540	34,204	11,320	61,810	132,565	109,590	
II зэрэглэл- 14	34,666	17,640	35,548	5,678	72,315	142,063	95,633	
III зэрэглэл -22	42,864	24,568	24,654	11,254	76,522	140,955	118,931	

I, II, III зэрэглэлийн өртөг тооцсон оношууд харилцан адилгүй, өөр хоорондоо ялгаатай. Нэг ижил түвшний I зэрэглэлийн СЭМТ, II, III зэрэглэлийн СЭМТ-өөс бага өртөгтэй байна.

Өртгийн төвөөр авч үзвэл, II зэрэглэлийн амбулаторын тусламж, үйлчилгээний өртгийн төвийн нийт зардал хамгийн өндөр өртөгтэй байгаа бол I зэрэглэл бага байна. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хамгийн өндөр өртгийг авч үзвэл, II, III зэрэглэл ойролцоо түвшинд, 1108 төгрөгний зөрүүтэй, I зэрэглэл, II зэрэглэлийн хооронд 9498 төгрөгний зөрүүтэй байна.

**БҮЛЭГ 3.5. ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТГИЙН ҮЗҮҮЛЭЛТ****3.5.1. Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээний хүртээмжийн үзүүлэлт**

АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Эрүүл мэндийн салбарын хөгжил-2” хөтөлбөрийн хүрээнд өрхийн эмнэлгүүдийг Улаанбаатар хот болон бүх аймгийн төвүүдэд үе шаттайгаар байгуулж, 2002 он гэхэд өрхийн эмнэлгийн тогтолцоонд шилжсэн.

2013 оны байдлаар өрхийн эрүүл мэндийн төвд 875 их эмч, 812 сувилагч, нийт 2501 их эмч, эмнэлгийн ажилчид тусламж, үйлчилгээ үзүүлж байна.

Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандартаар 1800-2000 хүн тутамд 1 их эмч ногдохоор стандартчилсан боловч, 2013 оны байдлаар 2107 хүн ногдож байна<sup>9</sup>.

Улаанбаатар хотын хувьд 1 өрхийн эмчид 2,282 хүн, аймгийн төвийн 1 өрхийн эмчид 1,802 хүн тус тус ногдож байна. Энэ нь Улаанбаатар хотод өрхийн эмчийн тоог 280-300 орчим нэмэх шаардлагатай гэсэн үг юм.

#### ХҮСНЭГТ 15. ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД<sup>10</sup>

Үзүүлэлт	Өрхийн эрүүл мэндийн төв		
	Улаанбаатар хот	Аймаг	Нийт дүн
Өрхийн эрүүл мэндийн төвийн тоо	136	92	228
Эмнэлгийн тоо	136	92	228
Их эмчийн тоо	555	320	875
Сувилагчийн тоо	527	285	812
Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо	3 834 822	2 035 472	5 870 294
Амбулаторын нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь	42.2	36.1	40.1
Нэг иргэний жилд үзүүлсэн удаа	3.0	3.0	3.0
Нэг өрхийн эмчид ногдох үзлэгийн тоо	6909.6	6360.9	9708.9
Жирэмсний эрт үеийн хяналтын хувь	86.4	87.1	86.7

2013 оны байдлаар 1 хүртэлх насны хүүхдийн хяналтын хувь 99.6 хувь, 1-5 насны хүүхдийн хяналтын хувь 96.1 хувь, ахмад настны хяналтын хувь 83.7 хувь байна. Амбулаторын нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэг 40.1%-ийг эзлэж, аймгийн өрхийн эрүүл мэндийн түвшинд 36.1%, Улаанбаатар хотын түвшинд 42.2%-тай байна.

Өрхийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт MNS 5292:2003 хэрэгжиж, 2011 онд шинэчлэгдэн MNS 5292:2011 “Өрхийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт” болон батлагдсан. Мөн өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний багцыг Эрүүл мэндийн сайдын 2013 оны 7 сарын 8-ны өдрийн 248 тоот тушаалаар батландан, мөрдөгдөж байна. Үүнд 6 чиглэлийн тусламж үйлчилгээг 320 орчим олон улсын өвчний ангиллын кодын дагуу үзүүлэхээр заасан.

#### ХҮСНЭГТ 16. ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙДАЛ<sup>11</sup>

	Үйлчлэх хүрээний өрхийн эрүүл мэндийн байдал			
	Нийт өрх	Үүнээс		
		Эрүүл өрх	Өвчлөлд бага өртөмтгий өрх	Өвчлөлд өртөмтгий өрх
Аймаг дүн	179979	85202	61007	33770
Улаанбаатар дүн	319569	146797	119699	53073
Улсын дүн	499548	231999	180706	86843
Улсын дүнд УБ-ын эзлэх хувь	63.9	63.27	66.23	61.1

Монгол улсын нийт өрхийн 46.4 хувийг эрүүл өрх, 36.2 хувийг өвчлөлд бага өртөмтгий өрх, 17.4 хувийг өвчлөлд өртөмтгий өрх эзэлж байна.


УБ хотын нийт өрхийн 45.9 хувь нь эрүүл, 37.5 хувь нь өвчлөлд бага өртөмтгий, 16.6 хувь нь өвчлөлд өртөмтгий өрх байна. Аймгийн нийт өрхийн 47.3 хувь нь эрүүл, 33.9 хувь нь өвчлөлд бага өртөмтгий, 18.8 хувь нь өвчлөлд өртөмтгий өрх байна.

<sup>9</sup> Эрүүл мэндийн үзүүлэлт, 2013 он, хуудас 45

<sup>10</sup> Эрүүл мэндийн үзүүлэлт, 2013 он, хуудас 45

<sup>11</sup> Эрүүл мэндийн статистик үзүүлэлт, 2012 он

**ДҮРСЛЭЛ 9. УЛААНБААТАР ХОТЫН ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЭМЧИЙН ҮЗЛЭГ**



Улаанбаатар хотын өрхийн эрүүл мэндийн төвийн их эмчийн үзлэгийн 45.0% нь урьдчилан сэргийлэх үзлэгт, 29.0% нь идэвхтэй хяналтад, 18.0 % нь амбулаторын үзлэгт, 7.0% нь идэвхтэй хяналтад, 1.0% нь дуудлагаар гэрийн үзлэгт зарцуулагдсан байна.


**3.5.2. Өрхийн эрүүл мэндийн төвийн төсвийн гүйцэтгэлийн үзүүлэлт**

Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2012 оны 6 сарын 05-ны 196/136 тоот “Өрхийн эрүүл мэндийн төвийн нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн тарифыг батлах тухай” тушаалын дагуу эрсдэл тооцсон нэг иргэнээр тооцон санхүүжүүлэх аргыг хэрэглэн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газраар дамжуулан өрхийн эрүүл мэндийн төв төсвөө авч байна.

Эрүүл мэндийн нэн шаардлагатай тусламжийн багцад ямар үйлчилгээ оруулах тухай Дэлхийн банк, ДЭМБ хамтран хэлэлцэж эдийн засгийн тооцоо судалгаа хийж нэн буурай хөгжилтэй орнуудад 12 ам доллар, дундаж хөгжилтэй орнуудад 21.5 ам долларт багтаан нэг иргэнд жилд үзүүлж болох ерөнхий тоо гаргасан байдаг<sup>12</sup>.

Өрхийн эрүүл мэндийн төвийн төсвийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг Улаанбаатар хотын 9 дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2011-2013 оны төсвийн төлвийг авч үзлээ.

**ДҮРСЛЭЛ 10. УЛААНБААТАР ХОТЫН ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ТӨСВИЙН ТӨЛӨВ<sup>13</sup>**



Дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвүүдийн санхүүжилт жил бүр нэмэгдэж ирсэн. Өсөлтийн хурд нь 1.2-1.6 хувь, цэвэр өсөлтийн 1 хувийн утга 18,282.2-474,596.5 мянган төгрөг байна.

Үйлчлэх хүрээний хүн амын тоо, насны бүтцээс шалтгаалан өрхийн эрүүл мэндийн төв дунджаар 60.0-120.0 сая төгрөгийн санхүүжилтийг төсвөөс шууд авдаг ба үүн дээр төсөл хөтөлбөрийн хандив нэмэгдэж нийт орлогыг бүрдүүлж байна.

2010 оноос эрүүл мэндийг дэмжих санд архи согтууруулах ундааны 1%, эмийн импортын татварын 2% тай тэнцэх хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулдаг болсон.

<sup>12</sup> Сумын эрүүл мэндийн төвийн нэн чухал үндсэн үйл ажиллагаа 2012 он

<sup>13</sup> НЭМГ-ын Өрхийн эрүүл мэндийн байгууллагуудын санхүүгийн гүйцэтгэл, 2012 он

Засгийн газрын 2011 оны 364 дүгээр тушаалаар батлагдсан “Өрхийн эрүүл мэндийн төвийн үлгэрчилсэн дүрэм”-нд зааснаар нийслэлд 8,000 хүн тутамд нэг өрхийн эмнэлэг байхаар заасан. Тус дүрмээр тооцвол нийслэлд **158.3** өрхийн эрүүл мэндийн төв ажиллах шаардлагатай болж байна.

### 3.5.3. Өрхийн эрүүл мэндийн амбулаторын тусламж, үйлчилгээний өртөг

Бид судалгаандаа өрхийн эрүүл мэндийн төвийн амбулаторын тусламж үйлчилгээгээр үзүүлэх 16 өвчнийг өртгийн төв болгон сонгосон. Өртгийн төвийг тооцохдоо цалин, эм, эмнэлгийн хэрэгслээр гаргалаа. Өрхийн эрүүл мэндийн төвийн тогтмол зардал нь тухайн өрхийн эрүүл мэндийн төвийн байрны халаалт дулааны шийдэл, талбайн хэмжээ зэргээс хамаарч дундачлан тооцоход бэрхшээлтэй байна. Төвийн дулаанд холбогдсон, өрөөнүүдийн талбайн хэмжээ стандартад нийцсэн өрхийн эрүүл мэндийн төв, орон нутгийн нам даралтаар халдаг өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тогтмол зардал их зөрүүтэй байна.


#### ХҮСНЭГТ 17. ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН АМБУЛАТОРЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ /ТӨГ/

№	Өртгийн төв	Цалингийн зардал	Нийт зардалд эзлэх хувь	Эм, эмнэлгийн хэрэгслийн зардал	Нийт зардалд эзлэх хувь	Нийт зардал
1	Уналт, таталт	1,596	30.5	3,630	69.5	5,226
2	Элэгний хатуурал, цус алдалт	3,404	34.8	4,590	47.0	9,772
3	Чихрийн шижин өвчтэй өвчтөний үзлэг	1382,6	9.0	14,780	91.4	16,163
4	Нойр булчирхайн хурц үрэвсэлтэй өвчтөний үзлэг	2489,7	15.0	14,260	85.0	16749,7
5	Уушигны багтраатай өвчтөний үзлэг	2,827	39.0	4,420	61.0	7,247
6	Халдварт шар өвчний үзлэг, халдварын голомтонд авах арга хэмжээ	12,899	39.0	20,386	61.2	33,285
7	Нүдний салстын үрэвсэл	2318,5	67.0	1,150	33.2	3,469
8	Нурууны мэдрэлийн үрэвсэл өвчтэй хүний үзлэг	1,659	48.0	1,800	52.0	3,459
9	Сүрьеэтэй өвчтөний үзлэг	12,700	91.0	1,208	8.7	13,908
10	Жирэмсний хожуу үеийн манас таталт	6,379	47.0	7,192	53.0	13,571
11	Уушигны хатгалгаа өвчтэй хүүхдийн үзлэг	5,293	65.7	2,768	34.3	8,061
12	Дунд чихний идээт үрэвсэл	1990,2	49.0	2,058	51.0	4048,2
13	Зүрхний бах өвчний үзлэг, эмчилгээ	2,735	87.9	378	12.1	3,113
14	Хүүхдийн шингэн алдалт суулгалт	2,101	33.9	4,100	66.1	6,201
15	Даралт ихсэх өвчтэй өвчтөний үзлэг, эмчилгээ	5,190	60.0	3,390	39.5	8,580
16	Умайн хүзүүний хорт хавдартай өвчтөнд үзүүлэх үзлэг	10,728	77.3	3,149	22.7	13,877
Дундаж		4,219	51.0	5,579	49.0	9,121

Өрхийн эрүүл мэндийн төвийн амбулаторын тусламж үйлчилгээний зардлын цалингийн дундаж зардал нь 4,219 төгрөг, эм, эмнэлгийн хэрэгслийн дундаж зардал нь 5,579 төгрөг байна. Хувиар авч үзвэл цалинд 51.0%, эм, эмнэлгийн хэрэгсэлд 49.0% зарцуулсан байна.

Сонгогдсон 16 өртгийн төвийн нийт зардлаар авч үзвэл 9,121 төгрөгийн дундаж өртөгтэй, 3,113-16,749.7 төгрөгийн хооронд хэлбэлзэж байна.

## ДҮРСЛЭЛ 11. ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ



Өвчнөөр авч үзвэл:

- Хамгийн өндөр өртөгтэй тусламж үйлчилгээ нь халдварт шар өвчний үзлэг, халдварын голомтонд авах арга хэмжээ 33,285 төгрөг, хамгийн бага нь зүрхний бах өвчний үзлэг, эмчилгээ 3,113 төгрөг байна.
- Цалингийн зардлын хамгийн өндөр нь 12,899 халдвар шар өвчний үзлэг, халдварын голомтонд авах арга хэмжээ бол, хамгийн бага нь уналт таталт 1,595.5 төгрөг байна.
- Эм, эмнэлгийн хэрэгслийн хамгийн өндөр зардалтай тусламж үйлчилгээнд халдварт шар өвчний үзлэг, голомтонд авах арга хэмжээ 20,386 төгрөг бол, хамгийн бага нь зүрхний бах өвчний үзлэг, эмчилгээ 378 төгрөгийн зардалтай байна.

### БҮЛЭГ 3.6. ӨРХ, СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ

Өрх, сумын эрүүл мэндийн төвийн үндсэн чиг үүрэг нь НЭМ-ийн тусламж үйлчилгээ байдаг. НЭМ-ийн тусламж үйлчилгээг 4 чиглэлийн тусламж үйлчилгээний багц, 16 чиглэлийн үзлэг, зөвлөгөө, сургалт, сурталчилгааг өртгийн төвөөр авлаа.

Түүнчлэн жирэмслэлтээс хамгаалах эм, тариа, бэлгэвч, ерөндөг зэргийг НҮБ-ын Хүн амын сангаас жилд сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд үнэ төлбөргүй олгож байгаа боловч төслийн хугацаа 2015 оноос дуусч байна. Хэрвээ төсөл зогсвол МУ-ын Засгийн газар буюу ЭМЯ-ны төсөвт тэр хэмжээний хөрөнгө шаардлагатай болно гэдэг үүднээс өртгийн төвийг тооцсон болно.

#### 3.6.1. Эх, хүүхдийн нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өртөг

Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг:

- Нярайд үзүүлэх тусламж, үйлчилгээ
- Жирэмсэн эхийн хяналт
- Төрөлт хоорондын хугацааг зохицуулах (Гэр бүл төлөвлөлт)

Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг:

- Нярайд үзүүлэх тусламж, үйлчилгээ
  - Гэрийн идэвхитэй эргэлт
- Жирэмсэн эхийн хяналт
  - Жирэмсэний хяналт, зөвлөгөө
- Төрөлт хоорондын хугацааг зохицуулах (Гэр бүл төлөвлөлт)
  - Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийн сурталчилгаа, зөвлөгөө

гэсэн 3 бүтээгдэхүүн, үйлчилгээнд өртөг тооцлоо.

### ХҮСНЭГТ 18. ЭХ, ХҮҮХДИЙН НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ


Тусламж үйлчилгээний багц		НЭМ-ийн тусламж үйлчилгээ буюу өртгийн төвүүд	Дундаж өртөг /төг/	
А. Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өртгийн төвийн багц			<b>СЭМТ</b>	<b>ӨЭМТ</b>
А:1	Нярайд үзүүлэх тусламж үйлчилгээ	Гэрийн идэвхтэй эргэлт	2,875	2,140
А:2	Жирэмсэн эмэгтэйн хяналт	Жирэмсэн эмэгтэй хяналт, зөвлөгөө	2,625	1,560
А:2	Төрөлт хоорондын хугацааг зохицуулах (Гэр бүл төлөвлөлт)	ЖСАХ-ийн сурталчилгаа, зөвлөгөө	2,244	2,480
<b>ДУНДАЖ ӨРТӨГ</b>			<b>2,581.3</b>	<b>2,060.0</b>

Нярайн гэрийн идэвхтэй эргэлт, асаргааг төрсний дараах 7 хоногоос 1 сар хүртэлх хугацаанд их эмч, сувилагч идэвхтэй эргэлт хийж, биеийн байдлыг хянадаг. Нярайн идэвхтэй эргэлтээр явахдаа усанд оруулах, зөв хөхүүлэх, эхийн биеийн байдлыг хянаж зөвлөгөө өгдөг байна.


1 нярайд үзүүлэх гэрийн идэвхтэй эргэлт, зөвлөгөөнд СЭМТ-өөс 735 төгрөгөөр, жирэмсэний хяналтад 1065 төгрөгөөр илүү өртөгтэй байгаа бол ӨЭМТ ЖСАХ-ийн сурталчилгаа, зөвлөгөөнд 236 төгрөгөөр, СЭМТ-өөс илүү өртөгтэй байна.

Эх, хүүхдийн тусламж, үйлчилгээний багцийн хамгийн их өртөг СЭМТ-ийн нярайн тусламж, үйлчилгээнд гарч байгаа бол хамгийн бага өртөг ӨЭМТ-ийн жирэмсэний хяналтын өртөг байна.

### ДҮРСЛЭЛ 12. СЭМТ-ИЙН ЭХ, ХҮҮХДИЙН НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ



### ДҮРСЛЭЛ 13. ӨЭМТ-ИЙН ЭХ, ХҮҮХДИЙН НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ





Эх, хүүхдийн Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний цалин, материалын дундаж өртгийг СЭМТ:ӨЭМТ-өөр харьцуулан авч үзвэл:

- 1 жирэмсэн эмэгтэйд зарцуулж буй жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл, сурталчилгаа, зөвлөгөөний дундаж өртгийг авч үзвэл цалин 1875:1820 (СЭМТ:ӨЭМТ) материалын үнэ 369:320 төгрөг байна. Өртөг харьцангуй ойролцоо түвшинд байна.
- Нэг жирэмсэн эхэд үзлэг зөвлөгөө өгөхөд дунджаар 2400:1365 төгрөгийн цалингийн зардал зарцуулсан бол, СЭМТ-ийн цалингийн зардал 1035 төгрөгөөр илүү байна. Харин ӨЭМТ-өөр эмнэлгийн хэрэгсэлд 195 төгрөг илүү зарцуулсан байна.
- Нэг нярайн гэрийн идэвтэй эргэлт, асаргаанд дунджаар цалинд 2625:1755 төгрөг зарцуулж байна. СЭМТ-ийн цалингийн зардал 870 төгрөгөөр илүү байна.
- Нэг нярайн гэрийн идэвтэй эргэлт, асаргааны эм, эмнэлгийн хэрэгсэлд 250:725 төгрөг зарцуулж байгаа нь ӨЭМТ нь 475 төгрөгийн илүү өртөгтэй гэсэн үг юм.

### 3.6.2. Насны ангилалаар үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өртөг:

#### Дархлаажуулалт:

- Дархлаажуулалтын өргөжүүлсэн хөтөлбөрийн хүрээнд хүүхдүүдийг вакцинжуулах
- Эмзэг бүлгийн болон шилжсэн гэр бүлийн хүүхдүүдийг нөхөн дархлаажуулалтанд хамруулах
- Вакцинжуулалтын дараа үеийн хариу урвал болон хүндрэлийг хянах, эцэг эхчүүдэд сургалт, сурталчилгаа, зөвлөгөө өгөх
- Ахмад настны тусламж үйлчилгээ
- Хүүхдийн тусламж, үйлчилгээний нийгмийн эрүүл мэндийн, сургалт, сурталчилгаа
- Өсвөр үеийн тусламж үйлчилгээ гэсэн 6 бүтээгдэхүүн, үйлчилгээнд өртөг тооцлоо.
- Насны ангиллаар үзүүлэх тусламж үйлчилгээний багц нь дотроо 6 бүлэг тусламж үйлчилгээтэй. 5-19 нас хүртэлх насны хүүхдийг өсвөр үеийн тусламж үйлчилгээ, үзлэг, сургалт, сурталчилгаа, зөвлөгөөнд НЭМ-ийн бүхий л хөтөлбөр стратеги хэрэгждэгээрээ онцлогтой байна.

### ХҮСНЭГТ 19. НАСНЫ АНГИЛЛААР ҮЗҮҮЛЭХ НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ

Тусламж үйлчилгээний багц		Өртгийн төвүүд	Нийт дундаж өртөг /төг/	
В. Насны ангилалаар үзүүлэх өртгийн төвийн багц			СЭМТ	ӨЭМТ
В:1	Хүүхдийн тусламж үйлчилгээ	Сургалт, сурталчилгаа, зөвлөгөө	3,410	2,005
В:2	Дархлаажуулалт	Дархлаажуулалтын өргөжүүлсэн хөтөлбөрийн хүрээнд хүүхдүүдийг вакцинжуулах	3,725	2,995
		Эмзэг бүлгийн болон шилжсэн гэр бүлийн хүүхдүүдийг нөхөн дархлаажуулалтад хамруулах	3,595	3,580
		Вакцинжуулалтын дараа үеийн хариу урвал болон хүндрэлийг хянах, эцэг эхчүүдэд сургалт, сурталчилгаа, зөвлөгөө өгөх	2,085	970
В:3	Ахмад настны тусламж үйлчилгээ	Ахмад настны асаргаа, сувилгаа	3,357	4,580
В:4	Өсвөр үеийн тусламж үйлчилгээ	Сургалт, сурталчилгаа, зөвлөгөө	3,471	3,660
<b>ДУНДАЖ ӨРТӨГ</b>			<b>3,273.8</b>	<b>2,965.0</b>

Дархлаажуулалтын өргөжүүлсэн хөтөлбөрийн хүрээнд хүүхдүүдийг вакцинжуулахад СЭМТ-өөр, өрхийн эрүүл мэндийн төвөөс 730 төгрөгөөр, эмзэг бүлгийн болон шилжсэн гэр бүлийн хүүхдүүдийг нөхөн дархлаажуулалтад хамруулахад 45 төгрөгөөр, вакцинжуулалтын дараа үеийн хариу урвал болон хүндрэлийг хянах, эцэг эхчүүдэд сургалт, сурталчилгаа, зөвлөгөө өгөхөд 1115 төгрөгөөр илүү өртөгтэй байна.

Харин ӨЭМТ-өөр, СЭМТ-өөс ахмад настны асаргаа, сувилгаанд 1223 төгрөг, өсвөр үеийн тусламж үйлгээний сургалт, сурталчилгаа зөвлөгөөнд 189 төгрөгийн илүү өртөгтэй байна.

Дархлаажуулалтын багцийн хамгийн их өртөг ӨЭМТ-ийн ахмад настны асаргаа, сувилгаанд, хамгийн бага өртөг вакцинжуулалтын дараа үеийн хариу урвал болон хүндрэлийг хянах, эцэг эхчүүдэд сургалт, сурталчилгаа, зөвлөгөө өгөх үйлчилгээнд гарч байна.

#### ДҮРСЛЭЛ 14. СЭМТ-ИЙН НАСНЫ АНГИЛЛААР ҮЗҮҮЛЭХ НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ



#### ДҮРСЛЭЛ 15. ӨЭМТ-ИЙН НАСНЫ АНГИЛЛААР ҮЗҮҮЛЭХ НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ /ТӨГ/



Сувилгаа нь бариа засал хийх, тариа хийх, хэсэг газрын эмчилгээ хийх, амин чухал үзүүлэлтийг үнэлэх, уян зүү тавих, катетр тавих зэрэг ордог байна.

Ахмад настны асаргаа, сувилгаа нь хэвтэрт байгаа болон, архаг хууч өвчтэй өндөр настанд гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээ юм.

Асаргаанд усанд оруулах, хэвтрийн байрлалыг солих, ахмад настан болон түүний асран хамгаалагч нарт асаргаа сувилгааны зөвлөгөө өгөх зэрэг ордог байна.

*Дархлаажуулалтын багцийн дундаж өртгийг цалин, материалын өртгөөр СЭМТ:ӨЭМТ-өөр харьцуулан авч үзвэл:*

- Дархлаажуулалтын өргөжүүлсэн хөтөлбөрийн хүрээнд хүүхдүүдийг вакцинжуулахад 1 хүүхдэд гарч буй цалин 3525: 2210 (СЭМТ:ӨЭМТ) төгрөг, материалын үнэ 200:785 төгрөг байна. СЭМТ-ийн цалин 1315-аар их байгаа бол ӨЭМТ-ийн материалын өртөг 585 төгрөгөөр өндөр байна.
- Эмзэг бүлгийн болон шилжсэн гэр бүлийн хүүхдүүдийг нөхөн дархлаажуулалтад хамруулахад, цалинд 3375:2600 төгрөг, материалд 220:980 төгрөг байна. СЭМТ-ийн

цалингийн зардал 775 төгрөгөөр, ӨЭМТөв материалд 760 төгрөгөөр тус тус илүү өртөг зарцуулсан байна.

- Вакцинжуулалтын дараа үеийн хариу урвал болон хүндрэлийг хянах, эцэг эхчүүдэд сургалт, сурталчилгаа, зөвлөгөө өгөхөд дунджаар 1875:910 төгрөгийн цалин, материалд 210:60 төгрөг гарсан байна. СЭМТөвийн цалин 965 төгрөг, материал 150 төгрөгөөр ӨЭМТ-өөс өндөр өртөгтэй байна.
- Нэг ахмад настны тусламж үйлчилгээнд дунджаар 3034:3575 төгрөгийн цалин, 323:597 төгрөг зарцуулсан. ӨЭМТөв цалинд 541 төгрөг, материалд 274 төгрөг илүү зарцуулсан байна.
- Өсвөр үеийн тусламж үйлчилгээнд дунджаар цалинд 3034:2925 төгрөг цалинд, 437:735 төгрөг ногдож байна. СЭМТөв цалинд 109 төгрөг, ӨЭМТөв материалд 298 төгрөгийн өртөг илүүтэй байна.
- Хүүхдийн тусламж, үйлчилгээний нийгмийн эрүүл мэндийн, сургалт, сурталчилгаа, зөвлөгөө өгөхөд дунджаар 2325:1755 төгрөгийн цалингийн зардалд гарчээ. СЭМТөв нь цалинд болон материалд илүү өртөг гарчээ.

### 3.6.3. Халдварт өвчний нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өртгийн төв

Халдварт өвчний тусламж, үйлчилгээний багц, өртгийн төв:


- Гэдэсний халдваруудын сургалт, сурталчилгаа
- ХДХВ/ДОХ/БЗДХ-ын Сэрэмжлүүлэг зөвлөгөө, урьдчилан сэргийлэх талаарх сурталчилгаа
- Сүрьеэ өвчний голомтод ариутгал хийх, хяналт тавих
- Зоонозын байгалийн голомтот болон шинэ дахин сэргэж буй халдварт өвчний айл өрх, байгууллагад гарсан халдвар өвчний голомтод ариутгал хийх, хяналт тавих гэсэн 4 багцын хүрээнд 4 өртгийн төвийг авч үзлээ.

#### ХҮСНЭГТ 20. ХАЛДВАРТ ӨВЧНИЙ НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ /ТӨГ/


Тусламж үйлчилгээний багц		НЭМ-ийн тусламж үйлчилгээ буюу өртгийн төвүүд	Тусламж үйлчилгээний өртөг /төг/	
Г: Халдварт өвчин			СЭМТ	ӨЭМТ
Г:1	Гэдэсний халдварууд	Сургалт, сурталчилгаа	1,150	1,980
Г:2	ХДХВ/ДОХ/БЗДХ	Сэрэмжлүүлэг зөвлөгөө, урьдчилан сэргийлэх талаарх сурталчилгаа	2,702	1,690
Г:3	Сүрьеэ	Айл өрх, байгууллагад гарсан халдвар өвчний голомтод ариутгал хийх, хяналт	3,308	2,560
Г:4	Зоонозын байгалийн голомтот болон шинэ дахин сэргэж буй халдварт өвчин	Айл өрх, байгууллагад гарсан халдвар өвчний голомтод ариутгал хийх, хяналт тавих	4,684	-
<b>ДУНДАЖ ӨРТӨГ</b>			<b>2,961.0</b>	<b>2,076,6</b>

1 хүнд гэдэсний халдваруудын сургалт, сурталчилгаанд дунджаар СЭМТ 1,150 төгрөг, ӨЭМТ 1980 төгрөгийн өртөгтэй, 830 төгрөгийн зөрүүтэй байна. ХДХВ/ДОХ/БЗДХ-аас сэрэмжлүүлэг зөвлөгөө, урьдчилан сэргийлэх талаарх сурталчилгаа хийхэд дунджаар 1,690-2,702 төгрөгийн өртөг гарсан байна. Сүрьеэ өвчний үед өвчний голомтод ариутгал хийх, хяналт тавихад 2,560-3,308 төгрөгийн өртөг гарч, СЭМТ-д 748 төгрөгөөр илүү байна. Мөн СЭМТ нь Зоонозын байгалийн голомтот болон шинэ дахин сэргэж буй халдварт өвчинд 4684 төгрөг зарцуулсан нь хамгийн өндөр өртөг болж байна.

### ДҮРСЛЭЛ 16. СЭМТ-ИЙН ХАЛДВАРТ ӨВЧНИЙ НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ



### ДҮРСЛЭЛ 17. ӨЭМТ-ИЙН ХАЛДВАРТ ӨВЧНИЙ НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ



Халдварт өвчний багцын дундаж өртгийг цалин, материалын өртгөөр СЭМТ:ӨЭМТ-өөр харьцуулан авч үзвэл:

- 1 тохиолдолд гарч буй сүрьеэ болон бусад халдварт өвчний айл өрх, албан байгууллагад гарсан өвчний голомтод ариутгал халдваргүйтгэл хийх, хяналт тавих, сургалт, сурталчилгаанд цалин 2888:1950 төгрөг, материалын үнэ 720:610 төгрөг байна. СЭМТ-ийн цалин 938-аар, материалын зардал 110 төгрөгөөр өндөр байна.
- ХДХВ/ДОХ/БЗДХ-ын талаарх сэрэмжлүүлэг зөвлөгөө, сургалт сурталчилгааг хийхэд нийт цалин 2442:1495 төгрөг, материалын үнэ 420:195 төгрөг байна. СЭМТ-ийн цалин 947-оор, материалын өртөг 225 төгрөгөөр өндөр байна.
- Гэдэсний халдварын сургалт, сурталчилгаа, зөвлөгөөнд цалин 2442:1495 төгрөг, материалын зардал 420:195 төгрөг байна. СЭМТ нь ӨЭМТ-өөс цалинд 947 төгрөг, материалд 225 төгрөг тус тус илүү өртөгтэй тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.

#### 3.6.4. Халдварт бус өвчний нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өртгийн төв:

##### Халдварт бус өвчин:

1. Хөхний хавдрын эрт илрүүлэг
2. Умайн хүзүүний хавдрын илрүүлэг
3. Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг
4. Артерийн гипертензи гэсэн 4 өртгийн төвийг сонгон тооцож үзлээ.

Зонхилон тохиолддог халдварт бус өвчний эрт илрүүлэг, үзлэгийг Монголын мянганы сорилтын сангийн эрүүл мэндийн төслийн хүрээнд анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад хэрэгжүүлэн, гарын авлага, эмнэл зүйн удирдамжаар хангасан байна.

Мөн төслийн хүрээнд үзлэг, шинжилгээ оношлогоонд шаардлагатай багаж тоног төхөөрөмж, урвалж бодис, нэг удаагийн хэрэгслийг үнэ төлбөргүй хангадаг байсан.


Гэсэн хэдий ч төслийн хугацаа дууссанаар үнэ төлбөргүй өгч байсан нэг удаагийн хэрэгсэл зэргийг улсын төсвөөс худалдан авч хэрэглэх шаардлага гарч байна.

**ХҮСНЭГТ 21. ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ**


Тусламж үйлчилгээний багц		Өртгийн төвүүд	Тусламж үйлчилгээний өртөг /төг/	
<b>Д: Халдварт бус өвчин</b>			<b>СЭМТ</b>	<b>ӨЭМТ</b>
Д:1	Халдварт бус өвчний багц	Хөхний хавдрын эрт илрүүлэг	4,636	3,465
		Умайн хүзүүний хавдрын илрүүлэг	6,610	5,456
		Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг	2,080	1,240
		Артерийн гипертензи	2,104	1,925
<b>ДУНДАЖ ӨРТӨГ</b>			<b>3,857.5</b>	<b>3,021.5</b>

Хөхний хавдрын эрт илрүүлэгт СЭМТ 4,636 төгрөг, өрхийн эрүүл мэндийн төв 3,465 төгрөг, СЭМТ нь 1,171 төгрөгөөр илүү өртөгтэйгээр тусламж үйлчилгээгээ хүргэж байна. Умайн хүзүүний хавдрын илрүүлэгт СЭМТ 6610 төгрөг, ӨЭМТ 5456 төгрөгийн өртөгтэй, СЭМТ нь 1154 төгрөгөөр илүү өртөгтэй тусламж үзүүлсэн байна. Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг СЭМТ-д 2080, ӨЭМТ-д 1240 төгрөгний өртөгтэй, СЭМТ нь 840 төгрөгийн илүү өртөгтэй тусламж үйлчилгээг үзүүлж байна. Артерийн гипертензи өвчнийг СЭМТ-д 2104 төгрөг, ӨЭМТ нь 1925 төгрөгийн өртөгтэй, СЭМТ нь 179 төгрөгөөр илүү өртөгтэй тусламж үйлчилгээг үзүүлж байна.

**ДҮРСЛЭЛ 18. СЭМТ-ИЙН ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ**



**ДҮРСЛЭЛ 19. ӨЭМТ-ИЙН ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ**



Тухайлбал СЭМТ:ӨЭМТ-өөр харьцуулан авч үзвэл:

- 1 хүний артерийн гипертензи өвчний эрт илрүүлэг, үзлэг зөвлөгөөний нийт дундаж өртөг нь 2016.5 төгрөг, цалинд 1850:1690 төгрөгний харьцаа харагдаж байна.
- Чихрийн шижин өвчний нийт эрт илрүүлэг, үзлэг, зөвлөгөөний нийт дундаж өртөг нь 1,660 төгрөг, цалинг авч үзвэл 1455:650, материалд 625:590 төгрөг байгаа нь цалинд нилээн зөрөөтэй байдал харагдаж байна.

- Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг, үзлэг, зөвлөгөө өгөхөд 6,033 төгрөгний өртөгтэй, үүнээс цалингийн зардал нь 3170:2275 төгрөг, эмнэлгийн хэрэгслийн зардал нь 3440:3181 төгрөг байна.
- Хөхний хорт хавдрын илрүүлэг, зөвлөгөөний дундаж өртөг 4,050.5 төгрөг бөгөөд үүнээс цалингийн зардал 2680:1625 төгрөг, эмнэлгийн хэрэгслийн зардал 1956:1840 төгрөгний зардалтай байна.

### ДӨРӨВ. СУМ, ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН САНХҮҮЖИЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ШААРДЛАГА, ХЭРЭГЦЭЭ

#### ХҮСНЭГТ 22. 2012 ОНЫ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨСӨВ

Сумын эрүүл мэндийн төвийн нэр	Баянжаргалан СЭМТ	Манхан СЭМТ	Дэрэн СЭМТ	Жаргалтхаан СЭМТ	Нийт	Дундаж
2012 оны төсөв	193,288.4	219,694.2	220,131.0	212,235.8	845,349.4	211,337.35
2013 оны төсөв	224,892.0	253,396.2	248,846.0	250,749.2	977,883.4	244,470.85
2013 оны төсөвт нэмэгдсэн дүн	31,603.6	33,702.0	28,715.0	38,513.4	132,534.0	33,133.5

2012 оны төсвөөс 2013 оны төсөв 13-18 хувиар нэмэгдсэн дүнтэй байна. Жил бүрийн инфляци, үнийн өсөлтийг тооцоолон төсвийг нэмэгдүүлэн тооцож байгаа боловч бодит хэрэгцээнд хүрэлцэхгүй байна. Сумын эрүүл мэндийн төвийн төсвийг эдийн засгийн ангиллын дагуу тооцож олгож байгаа нь иргэдэд үнэ төлбөргүй жигд үзүүлэх давуу талтай ч ажлын үр дүн, санал санаачлагыг хөхүүлэн дэмждэггүйгээрээ сул талтай юм. Иймд цаашид сумын эрүүл мэндийн төвийн санхүүжилтийг гүйцэтгэлээр /тохиолдлоор/ санхүүжүүлэх, өөрөөр хэлбэл нэмэлт эх үүсвэр шаардлагатай болж байна.

#### ХҮСНЭГТ 23. I.II.III ЗЭРЭГЛЭЛИЙН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДУНДАЖ ӨРТӨГ

Тусламж үйлчилгээний өртөгийн төв (тоо)	Цалин		Эм, эмнэлгийн хэрэгсэл		Тогтмол зардал		Нийт зардал	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
<b>Амбулаторын тусламж, үйлчилгээний өртөг (дундаж)</b>								
I зэрэглэл -14	4,869	43.7	2,865	25.4	3,390	30.9	10,718	100.0
II зэрэглэл -16	3,886	31.7	1,540	12.7	7,085	55.6	12,511	100.0
III зэрэглэл -24	4,032	27.1	3,922	26.6	5,467	46.3	13,420.9	100.0
Дундаж							12,216.6	100.0
<b>Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний өртөг (дундаж)</b>								
I зэрэглэл-11	38,049	32.1	19,729	16.5	61,810	51.5	119,588	100.0
II зэрэглэл- 14	26,417	21.5	23,479	18.7	72,315	59.8	122,211	100.0
III зэрэглэл -22	36,365	27.9	17,116	13.1	76,522	59.0	130,003	100.0
Дундаж							123,934	100.0

#### ХҮСНЭГТ 24. I.II.III ЗЭРЭГЛЭЛИЙН СЭМТ-ИЙН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ

СЭМТ	Цалингийн зардал	Эм, эмнэлгийн хэрэгсэл	Шатахууны зардал	Нийт зардал
I зэрэглэлийн СЭМТ	10,284.4	5,259.2	13,300.0	28,843.6
II зэрэглэлийн СЭМТ	13,483.6	2,230.4	17,080.0	32,794.0
III зэрэглэлийн СЭМТ	15,403.4	3,689.4	20,558.0	39,650.8
Нийт	39,171.4	11,179.0	50,938.0	101,288.4
<b>Дундаж</b>	<b>9,792.85</b>	<b>2,794.75</b>	<b>12,734.5</b>	<b>25,322.1</b>

**ХҮСНЭГТ 25. СЭМТ, ӨЭМТ-ИЙН НЭМТҮ-НИЙ ДУНДАЖ ӨРТӨГ**

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	СЭМТ-ийн НЭМТҮ-ний дундаж өртөг	ӨЭМТ-ийн НЭМТҮ-ний дундаж өртөг	СЭМТ, ӨЭМТ-ийн НЭМТҮ-ний дундаж өртөг
Эх, хүүхдийн	2,581.3	2,060.0	2,320.6
Насны ангиллаар үзүүлэх	3,273.8	2,965.0	3,119.4
Халдварт өвчний	2,961.0	2,076.6	2,518.5
Халдварт бус өвчний	3,857.5	3,021.5	3,439.5
<b>ДУНДАЖ ӨРТӨГ</b>	<b>3,168.4</b>	<b>2,530.8</b>	<b>2,849.5</b>

**ХҮСНЭГТ 26. СУДАЛГААНД ХАМРАГДСАН СЭМТ-ИЙН АМБУЛАТОРИЙН ҮЗЛЭГ, ЭМЧИЛГЭЭ, ХЭВТҮҮЛЭН ЭМЧИЛСЭН БОЛОН НЭМ-ИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ 2012 ОНЫ СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ**

Сумын эрүүл мэндийн төвийн нэр	Баянчандмань СЭМТ	Манхан СЭМТ	Дэрэн СЭМТ	Жаргалтхаан СЭМТ	ТҮ авсан нийт хүний тоо	ТҮ авсан дундаж хүний тоо
Амбулаторын үзлэг, эмчилгээ хийлгэсэн хүний тоо	8,975	10,990	8,860	6,170	34,995	8,748.75
Хэвтүүлэн эмчилсэн хүний тоо	859	723	532	820	2,934	733.5
Яаралтай тусламж (дуудлагаар) үзүүлсэн хүний тоо	769	550	501	617	2,437	609.25
НЭМ-ийн тусламж үйлчилгээ	4,950	4535	6,421	5,232	21,138	5,284.5

Сумын эрүүл мэндийн төвд амбулаторийн үзлэг, эмчилгээ дунджаар 8,748 хүн, хэвтүүлэн эмчилсэн 733.5 хүн, яаралтай тусламж(алсын дуудлагаар) үзүүлсэн хүн 609.25, НЭМ-ийн тусламж үйлчилгээ буюу хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд сургалт сурталчилгаа, үзлэг зөвлөгөө, мэдээлэл өгсөн хүний дундаж 5284.5 хүн тус тус байна.

**ХҮСНЭГТ 27. ДООРООС ДЭЭШ ӨРТӨГ ТООЦОХ АРГААР ТООЦСОН СЭМТ-ИЙН ТӨСӨВ**

Тусламж үйлчилгээний төрөл	Үзлэг, эмчилгээ хийлгэсэн хүний дундаж тоо	Нэг үйлчлүүлэгчдэд зарцуулж буй эмчилгээний дундаж өртөг	Нийт шаардлагатай төсөв
Амбулаторын үзлэгийн дундаж хүний тоо	8,748.75	12,216.6	106,879,979.25
Хэвтүүлэн эмчилсэн хүний тоо	733.5	123,932.3	90,904,342.0
Яаралтай тусламж үзүүлсэн хүний тоо	609.25	25,322.1	15,433,820.0
НЭМ-ийн тусламж үйлчилгээ	5,284.5	3,168.4	16,743,409.8
<b>Бүгд зардал</b>			<b>229,961,551.0</b>
Аж ахуйн зардал Бүгд зардал– 40% /нэг удаагийн тэтгэмж урамшуулал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, бичиг хэрэг, тослох материал, шуудан, утас интернет, томилолт, элэгдэл хорогдол, нормын хувцас, зөөлөн эдлэл, эд хогшил худалдан авах, ... гэх мэт/ <b>НИЙТ</b>			91,984,620.4 <b>321,946,171.4</b>

**ХҮСНЭГТ 28. 2013 ОНЫ СЭМТ-ИЙН ТӨСӨВ БОЛОН ӨРТГИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮНД ГАРСАН ТӨСВИЙН ХАРЬЦУУЛСАН ХҮСНЭГТ**

СЭМТ төсөв	Нийт дүн /төг/	Хувь	СЭМТ-ийн хүн ам дунджаар	СЭМТ-ийн нэг хүнд ногдох төсөв
Доороос дээш өртөг тооцох аргаар тооцсон СЭМТ-ийн дундаж төсөв	321,946,171.4	131.6%	4,876	66,026.6
2013 оны эдийн засгийн ангиллаар тооцсон СЭМТ-ийн дундаж төсөв	244,470,850.0	100%	4,876	50,137.6
Зөрүү	77,475,321.4	31.6%		15,889.0



## ХҮСНЭГТ 29. 2012 ОН, 2013 ОНЫ ӨЭМТ-ИЙН ТӨСӨВ

Төсөв /оноор/	“ЭРҮҮЛ ӨРХ” ӨЭМТ	Хүн амын тоо	
2012 оны төсөв	118,470,000.0	15,480	7,653.1
2013 оны төсөв	133,618,900.0	16,364	8,165.4
Зөрүү	15,148,900.0		

## ХҮСНЭГТ 30. ӨЭМТ-ИЙН АМБУЛАТОРИЙН ҮЗЛЭГ, ЭМЧИЛГЭЭНИЙ ДУНДАЖ ӨРТӨГ

Өртгийн төв	Цалингийн зардал	Зардалд эзлэх хувь	Эм, эмнэлгийн хэрэгслийн зардал	Зардалд эзлэх хувь	Дундаж зардал
Дундаж	4,219.0	51.0	5,579.0	49.0	9,121.0
ӨЭМТ-ийн НЭМ-ийн тусламж үйлчилгээний дундаж зардал					2,530.8
ӨЭМТ-ийн нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн тариф/ЭМ-ийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2012 оны 6 сарын 05-ны өдрийн 196/136-р тушаал/					
	Íàñíó àçëýä		Íðøëí ñóóààà äàçàð		Íýä ëäýýýýð òíïòííí òàðëë/ò°ä
1	0-5 íàñ òçäòýë		Ãýð òíðíëëë		22463
			Ààéøëí òíðíëëë		19746
2	5-16 íàñ òçäòýë		Ãýð òíðíëëë		9558
			Ààéøëí òíðíëëë		8879
3	16-49 íàñíó ýìýäòýë÷çä		Ãýð òíðíëëë		10237
			Ààéøëí òíðíëëë		10237
4	60-ñ äýýø íàñ		Ãýð òíðíëëë		14312
			Ààéøëí òíðíëëë		12954
5	Áóñàä íàñ		Ãýð òíðíëëë		8199
			Ààéøëí òíðíëëë		7520
6	Íëéò ñàíðççæëëðëé äçí		Ãýð òíðíëëë		
			Ààéøëí òíðíëëë		

ӨЭМТ-ийн иргэнд ногдох дундаж нэг иргэнээр тооцсон тариф нь 12,410.5 төгрөг байна. Үүнээс 40 хувь нь тогтмол зардал гарна гэж тооцвол 4,964.2 төгрөг нь тогтмол зардалд гарна. Үүнийг нэг иргэнээр тооцсон дундаж тарифаас хасахад 7,446.3 төгрөг гарч байна. Энэ нь тусламж үйлчилгээнд зарцуулагдах төсөв гэж үзвэл доороос дээш өртөг тооцож гарсан тарифтай (9,121.0 төг) харьцуулахад 1,674.7 төгрөг буюу 22,5 хувиар бага байна.

## ХҮСНЭГТ 31. 2013 ОНЫ “ЭРҮҮЛ ӨРХ” ӨЭМТ-ИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ

Тусламж үйлчилгээний төрөл	Амбулаторын үзлэг, эмчилгээ, зөвлөгөө	Гэрийн идэвхтэй эргэлт	Гэрийн дуудлага	Нийт
Өрхийн эмчийн үзлэг	12,581	5,153	3,829	21,563
НЭМ-ийн тусламж үйлчилгээ				19,382
<b>Нийт</b>				<b>40,945</b>

## ХҮСНЭГТ 32. ҮЙЛДЭЛД СУУРИЛСАН ӨРТӨГ ТООЦОХ АРГААР ТООЦСОН ӨЭМТ-ИЙН ТӨСӨВ

Нийт үйлчлүүлэгчийн тоо	Нэг үйлчлүүлэгчид зарцуулсан өртөг	Нийт өртөг /шаардагдах төсөв/
21,563	9,121	196,676,123.0
19,382	2,530.8	49,051,965.6
<b>НИЙТ</b>		<b>245,728,088.6</b>

### ХҮСНЭГТ 33. 2013 ОНЫ ӨЭМТ-ИЙН ТӨСӨВ БОЛОН ӨРТГИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮНД ГАРСАН ТӨСВИЙН ХАРЬЦУУЛСАН ХҮСНЭГТ

Төсөв	Төсвийн дүн /төг/	Хувь
Доороос дээш өртөг тооцох аргаар тооцсон СЭМТ-ийн дундаж төсөв	245,728,088.6	183,9%
2013 оны нэг иргэнээр тооцсон ӨЭМТ-ийн дундаж төсөв	133,618,900.0	100%
Зөрүү	112,109,188.6	83,9%

Үүнээс харахад ӨЭМТ-ийн төсвийг 83,9 хувийн зөрүүтэй байна. Энэ нь доороос дээш өртөг тооцох аргаар тооцсон нийт төсөвт нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардал орсон байгаа зардал юм. Цаашид анхан шатны тусламж үйлчилгээний бодит өртгийн судалгаанд үндэслэн нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн тарифыг нэмэгдүүлэх эсвэл тогтмол зардлыг эдийн засгийн ангиллаар, хувьсах буюу тусламж үйлчилгээний зардлыг нэг иргэнээр тооцон санхүүжүүлж болох юм. 2014 оны Эрүүл мэндийг дэмжих сан иргэн бүрт 845,5 төгрөгийг нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зарцуулахаар шилжүүлсэн байна.

#### ДҮГНЭЛТ

- Монгол улсын хэмжээнд 228 өрхийн эрүүл мэндийн төв, 271 сумын эрүүл мэндийн төв, 39 сум дундын эмнэлгийн 10574 эмч, ажилтан тусламж, үйлчилгээ үзүүлж байна.
- Амбулаторын тусламж үйлчилгээний дундаж өртөг I зэрэглэлийн СЭМТ-д 10,718.0 төгрөг, II зэрэглэлийн СЭМТ-д 12,511.0 төгрөг, III зэрэглэлийн СЭМТ-д 13,427.0 төгрөг байна. III зэрэглэлд амбулаторын өртөг хамгийн өндөр, энэ нь I зэрэглэлээс 1.2 дахин, III зэрэглэлээс 0.1 дахин өндөр байна.
- Хэвтүүлэн эмчлүүлэх тусламж үйлчилгээний дундаж өртөг I зэрэглэлд 119,588 төгрөг, II зэрэглэлд 122,211.0 төгрөг, III зэрэглэлд 130,003.0 төгрөг байна. III зэрэглэлд хамгийн өндөр, энэ нь I зэрэглэл, II зэрэглэлээс 1.1 дахин өндөр байна.
- Амбулаторын тусламж, үйлчилгээнд цалингийн дундаж зардал I зэрэглэлд 4,869.0 төг, II зэрэглэлд 3,886.0 төг, III зэрэглэлд 2,032.0 төг байна. I зэрэглэлийн цалингийн дундаж зардал II зэрэглэлээс 1.3 дахин, III зэрэглэлээс 2.4 дахин өндөр байна. I зэрэглэлд цалингийн дундаж зардал өндөр байгаа нь хүний нөөц цөөхөн, хавсран ажиллаж, 20.0%-40.0% нэмэгдэл цалин авч байгаатай холбоотой байна.
- Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд цалингийн зардал I зэрэглэлд 38,049 төг, II зэрэглэлд 26,417.0 төг, III зэрэглэлд 36,365.0 төг байна. I, III зэрэглэл ойролцоо түвшинд, 1046 төгрөгний зөрөөтэй байна.
- Амбулаторын эм, эмнэлгийн хэрэгслийн нийт зардалд эзлэх дундаж зардал I зэрэглэлд 2,865.0 төгрөг, II зэрэглэлд 1,540.0 төгрөг, III зэрэглэлд 1,922.0 төг байна. I зэрэглэлийн эм, эмнэлгийн хэрэгслийн дундаж зардал өндөр байгаа нь амбулаториор их эмчилгээг хийж байгаатай шууд хамааралтай байна.
- Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний эм, эмнэлгийн хэрэгслийн нийт зардалд эзлэх дундаж зардал I зэрэглэлд 19,729 төгрөг, II зэрэглэлд 23,479.0 төгрөг, III зэрэглэлд 17,116.0 төг байна. II зэрэглэлд өртөг өндөр, энэ нь I зэрэглэл, III зэрэглэлээс 1.2 дахин өндөр байна.
- Тогтмол зардлын дундаж зардал амбулаториор I зэрэглэлд 3,390.0 төгрөг, II зэрэглэлд 7,085.0 төгрөг, III зэрэглэлд 3,467.0 төгрөг байна. Амбулаторын үйлчилгээний тогтмол зардал нь эмчилгээний хугацаанаас хамаарч байна.
- Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний тогтмол зардлыг тооцохдоо I. II. III зэрэглэлд дундаж ор хоногийг ижилхэн 8 хоногоор авахад, I зэрэглэлд 61,810.0 төгрөг, II зэрэглэлд 72,315.0 төгрөг, III зэрэглэлд 76,522.0 төгрөг байна.

- Өрхийн эрүүл мэндийн төвийн амбулаторын тусламж үйлчилгээний дундаж өртөг 9,121.0 төгрөг, үүнээс цалингийн зардал 5,579.0 төг, эмнэлгийн хэрэгслийн зардал 4,219.0 төгрөг байна.
- Амбулаторын тусламж, үйлчилгээний өртгийн төвийг өвчний оношоор авч үзвэл I зэрэглэлд хамгийн өндөр өртөгтэй өртгийн төв нь уушигны гуурсын архаг үрэвсэл( 15,966.0төг), II зэрэглэлд төрөлтийн 3-р үеийн цус алдалт (25,320.0 төг), III зэрэглэлд В вирусын цочмог үрэвсэл (10,897.0 төг) байна. Харин бага өртөгтэй, өртгийн төвд томуу өвчин (5,181.0 төг ) II зэрэглэлд сульдаа (7,238.0 төг), III зэрэглэлд нойр булчирхайн цочмог үрэвсэл (4,746,0) орж байна.
- Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний өртгийн төвийг өвчний оношоор авч үзвэл I зэрэглэлд хамгийн өндөр өртөгтэй өртгийн төв нь дунд чихний идээт үрэвсэл (132,565 төг), II зэрэглэлд гадна чихний буглаа (142,063.0 төг), III зэрэглэлд гүйлсэн булчирхай орчмын буглаа (140,955 төг) байна. Бага өртөгтэй өртгийн төв нь I зэрэглэлд пневмония (109,590.0 төг), II зэрэглэлд хөхний тодорхойгүй үүсвэр (95,633.0 төг), III зэрэглэлд зүрхний цочмог шигдээс (118,931.0 төг) орж байна.
- Өрхийн эрүүл мэндийн төвийн хамгийн өндөр өртөгтэй тусламж үйлчилгээ нь халдварт шар өвчний үзлэг, халдварын голомтонд авах арга хэмжээ 33,285 төгрөг, хамгийн бага нь зүрхний бах өвчний үзлэг, эмчилгээ 3,113 төгрөг байна.
- Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эх, хүүхдийн нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцын нярайн гэрийн идэвхитэй эргэлт өндөр, (2,875.0), жирэмсэний хяналт (1,560.0) бага өртөгтэй байна.
- Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн насны ангилалаар үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцын дархлаажуулалтын өргөжүүлсэн хөтөлбөрийн хүрээнд хүүхдүүдийг вакцинжуулалт өндөр (3,725.0) өртөгтэй, вакцинжуулалтын дараа үеийн хяналт (970,0) бага өртөгтэй байна.
- Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн халдварт өвчний нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцын сүрьеэ өвчний үед голомтод ариутгал хийх, хяналт тавихад өндөр (3,308.0) өртөг, гэдэсний халдварын үед сургалт, сурталчилгаа хийхэд бага (1,150.0) өртөг гарсан байна.
- Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн халдварт бус өвчний нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцын умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг, үзлэг, зөвлөгөө өндөр (6,610.0) төгрөг, чихрийн шижин өвчний эрт илрүүлэг хамгийн бага (1,240.0) өртөг гарсан байна.
- Доороос дээш өртөг тооцох арга(Activity based costing) –аар тооцоход СЭМТ-ийн төсвийг 31-35 хувиар нэмэгдүүлэх, ӨЭМТ-ийн төсвийг 60-85 хувиар нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага байна.
- Эдийн засгийн ангиллаар тооцсон 2013 оны СЭМТ-ийн нийт төсвийг сумын дундаж хүн амын тоонд хуваахад нэг иргэнд 50,137.6 төгрөг, доороос дээш өртөг тооцох аргаар тооцсон нийт төсвийг сумын хүн амын дундажид хуваахад нэг иргэнд ногдох зардал нь 66,026.6 төгрөг байна.
- ӨЭМТ-ийн нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн тарифын нэг иргэнд ногдох дундаж тариф нь 12,410.5 төгрөг үүнээс тогтмол зардлын хувийг хасахад нэг иргэнд ногдох хувьсах зардал буюу эмчилгээнд шаардлагатай тариф нь 7,446.3 төгрөг байна. Үүнийг доороос дээш өртөг тооцох аргаар тооцсон нэг иргэнд шаардлагатай 9,121.0 төгрөгтэй харьцуулахад 22,5 хувиар бага байна.

